



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН, СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



ЗЭЭЛДЭГЧИЙН ТОО-1547



Албан шаардлагын хэрэгжилт



Аймаг, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй, өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжүүдийн хэрэгжилт хангалтгүй байна.

Ховд хот

2018 оны 11 сар

Агуулга

<p>Аудитыг гүйцэтгэж тайланг бэлтгэсэн:</p> <p>ҮАГ-ын харьяа Ховд аймаг дахь аудитын газар</p> <p>2018 оны 11 дүгээр сар</p> <p>Уг тайланг ҮАГ-ын Веб сайтаас үзнэ үү. www.audit.gov.mn</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70432545 дугаарын утас, 70433061 дугаарын факсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар Ховд аймаг дахь Төрийн Аудитын газар 3 давхар</p>	<p>Товчилсон үгийн жагсаалт 1</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл 3</p> <p>Бүлэг 1 <i>Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс авах урьдчилсан жагсаалтыг гарган нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулаагүй, хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд нь үр дүнтэй болсон талаар ажлын тайлан мэдээ байхгүй байна.</i> 4</p> <ol style="list-style-type: none"> 1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг болон бусад эх үүсвэрийг хууль, журамд заасан нэр төрөл тус бүрээр бодитой төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна. 5 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй ажлыг баталж санхүүжүүлсэн, зарим ажлын гүйцэтгэл хангалтгүй, заавар журмыг мөрдөж ажиллаагүйгээс сангийн зарцуулалт үр дүн муутай байна. 6 3. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд ИТХ болон Дотоод аудит хяналтын алба нь хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна. 19 <p>Бүлэг 2. <i>Журамд заасан шалгуурыг хангаагүй зээлдэгчдэд зээл олгосон, зээлийг зориулалт бусаар зарцуулсан, зээлийг гэрээнд заасан хугацаанд зээлээ төлдөггүй зэргээс шалтгаалж сангийн хөрөнгийн үр өгөөжийг буурчээ.</i> 21</p> <ul style="list-style-type: none"> • Сумдын сум хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүй, зээл, зээлийн хүүгээс орох орлогын эх үүсвэрийн бүрэн төвлөрүүлээгүйгээс сангийн зээлийн эргэц 21 удаашралтай байна • Чанаргүй, эдийн засгийн тооцоо, судалгаа муутай төсөлд барьцаа хөрөнгөгүйгээр зээл олгож, зээлийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж байгаа нь журмын холбогдох заалтуудтай нийцэхгүй байна. 24 • Журмын хэрэгжилт хангаагүй зээлдэгчид зээл олгосноос зээлээ хугацаандаа төлдөггүй эрсдэл түгээмэл байна. 27 • Сум хөгжүүлэх сангийн төслийн үр дүнд ажлын байр бодитой нэмэгдсэн эсэхийг баталгаажуулах боломжгүй байна. 27 • Сумдын ИТХ нь журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна. 28 • Жаргалант сумын СХС-ийн төсөл сонгон шалгаруулах болон зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлүүд нь журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаагүй 29 байна. <p>Бүлэг 3. <i>Сангуудын хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, сангийн үйл ажиллагааг нийтэд ил тод мэдээлээгүй, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.</i> 32</p> <ul style="list-style-type: none"> • ОНХС-гийн өмнөх аудитаар илэрсэн зөрчилд өгсөн актыг барагдуулж ажилласан ч албан шаардлагын 64.1 хувийг арилгаагүй, зөвлөмжийн 20.5 хувийг хэрэгжүүлээгүй байна. 32 • Сум хөгжүүлэх сангийн хэрэгжилтэд аймаг, сумдын ИТХ болон мэргэжлийн байгууллага, 34 холбогдох албан тушаалтнууд журамд заасан эрх үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна. <p>Аудитын дүгнэлт</p> <ul style="list-style-type: none"> • <i>ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар сумууд иргэдийн хэрэгцээнд нийцсэн ажлуудыг хэрэгжүүлж байгаа ч Аймгийн ОНХС, Үенч сум, Дарви сум, Цэцэг сум, Жаргалант сумын ОНХС-гийн гүйцэтгэл хангалтгүй, ОНХС-аас санхүүжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт сул байна.</i> 36 • <i>Сум хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүй, зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт хангалтгүй, сангийн хөрөнгийн эргэц удаашралтай, журамд заасан шалгуурыг хангаагүй зээлдэгчдэд зээл олгосон, зээлийг зориулалт бусаар зарцуулсан нь сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан, сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, сангийн үйл ажиллагааг нийтэд ил тод мэдээлээгүй, өмнөх гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.</i> 36 <p>Аудитын зөвлөмж 36</p> <p>Тэргүүлэх Аудиторын тушаал 42</p> <p>Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал: 43</p>
---	---

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХААЖД	Хүнс хөдөө аж ахуйн жижиг дунд үйлдвэрийн
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
СХС	Сум хөгжүүлэх сан
ХАА	Хөдөө аж ахуй
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
МАА	Мал аж ахуй
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТОСК	Төрийн орон сууцны корпораци
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл

1.1.Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2018 оны аудитын сэдэв батлах тухай 03 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаалаар баталсан Үндэсний Аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Ховд аймаг Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

1.2 Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сан болон сум хөгжүүлэх сангийн зарцуулалт, үр дүнд нийцлийн аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэнэ.

Аудитын зорилтыг ханган биелүүлэхийн тулд дараах чиглэлээр аудит хийнэ.

- Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх,
- Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх,
- Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх,

1.3 Аудитын хамрах хүрээ:

Аймгийн СТСХ, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, ХХААГ, сумдын ЗДТГ, сумдын орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн 2017 оны үйл ажиллагаа болон бусад холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг хамруулна. Аудитын хугацаанд Жаргалант сумын ОНХС-гийн зарцуулалтад иргэд, олон нийт хэвлэл мэдээллийн хэрэгслээр ихээхэн шүүмжлэл дагуулсан асуудлууд хөндөгдсөн тул тус сумын ОНХС-гийн 2018 оны ажлуудын гүйцэтгэлийг нэмж хамрууллаа.

1.4 Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын түр журамыг баримтлан Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хүнс хөдөө аж ахуйн газар, аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалтын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, сумдын ЗДТГ болон холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, судалгаа авч шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад Төсвийн тухай хууль, Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 153 дугаар тогтоол, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол, МУ-ын аж үйлдвэрийн сайдын 72 дугаар тушаал, Сангийн сайдын 2012 оны 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл

боловсруулах журам”, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”, аймгийн Засаг даргын 2016 оны 02 тоот албан даалгавар болон бусад холбогдох хууль тогтоомж, бусад эрхийн актууд

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар удирдан, аудитын менежер А.Цэцэгсүрэн аудитын арга зүйгээр хангаж, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нарантуул аудитор Д.Эрдэнэцэцэг, Д.Мөнхтулга, Д.Балжинням нар гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:

Аудитын тайлангийн I бүлэгт орон нутгийн хөгжлийн сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналт, II бүлэгт сум хөгжүүлэх сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналт III бүлэгт өмнөх оны аудитын акт албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар тайлагнаж ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал гэсэн агуулгаар бичлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолд “Орон нутгийн хөгжлийн сан гэж орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон орлогын шилжүүлэг болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, хуваарилан зарцуулах хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай журам”, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг баримтлан хэрэгжүүлж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг 2017 оны 4 дүгээр хуралдааны 02/3 тоот тогтоолоор сумдын ОНХС-д 921.4 сая, аймгийн ОНХС-д 856.9 сая, бүгд 1778,3 сая төгрөгөөр баталжээ.

Сум орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлээр дэмжих зорилгоор 2011 оны 134 дүгээр тогтоолоор сумдын сум хөгжүүлэх сангийн эх үүсвэр байгуулагдаж зохицуулагджээ. 2011-2014 онд улсын хэмжээнд нийт 84.0 тэрбум төгрөгийг улсын төсвөөс “Сум хөгжүүлэх санд” татан төвлөрүүлж 330 суманд хүн ам, эдийн засгийн боломжит нөхцөл байдлаас хамааруулж сумуудад хуваарилалт хийсэн байна.

Улмаар Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмаар сангийн хөрөнгийг удирдах, төсөл сонгон шалгаруулах, сангаас зээл олгох, эргэн төлөлт болон сангийн үйл ажиллагааг иргэдэд ил тод нээлттэй явуулахтай холбогдсон харилцааг шинэчлэн зохицуулжээ.

Сум хөгжүүлэх сангийн зээл нь арилжааны банкаар дамжихгүй, орон нутаг өөрөө бие дааж шийдвэрлэдэг, сумын засаг дарга шууд гэрээ байгуулан олгодог, сум хөгжүүлэх сангаас шууд санхүүжүүлдэг, барьцаа хөрөнгийн баталгааг арилжааны банк шиг хатуу нөхцөлгүй, зээлийн гэрээг орлогын эх үүсвэрээс хамааруулан хийх боломжтой, улсын төсөвт эх үүсвэрийг буцаан татдаггүй учир сумын хөгжилд байнга тасралтгүй эргэх санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх зэрэг давуу талтай, орон нутагт жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, иргэдийн амьжиргааг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зориулалт бүхий сан юм.


Ховд аймгийн хэмжээнд 2010 онд 13.8 сая, 2011 онд Сангийн сайд, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 100/А/59 тоотор 1225.0 сая, Хөдөлмөрийн сайдын 2012 оны А/69, 2013 оны А/38 тоот тушаалаар 2450.0 сая, 2014 оны А/141 тоот тушаалаар 635.23 сая, бүгд 4324.1 сая төгрөгний санхүүжилт батлагдан эх үүсвэр бүрджээ.

Бүлэг 1.1: Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг болон бусад эх үүсвэрийг хууль, журамд заасан нэр төрөл тус бүрээр бодитой төлөвлөж, бүрдүүлж, хваарилсан байна.

ОНХНС-гаас олгох шилжүүлэг болон бусад эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөжээ.

1.1.1 ОХНС-аас Ховд аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59-р зүйлийн 59.3¹, 59.4²-д заасны дагуу усны үнийн татаас, хот тохижуулах үйлчилгээ, мал эмнэлгийн үйлчилгээний зардалд тус тус хуваарилан, ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын дагуу тооцоолсон байна. Аймгийн ОНХС-гийн батлагдсан санхүүжилтийг харуулбал: /График-1/

Дээрх графикаас харахад улсын ОНХНС-аас 2017 онд Ховд аймгийн ОНХС-д анх батлагдсан дүнгээс тодотголоор Олон улсын байгууллагын хандив 395.0 сая, АМНАТ мега төслийн санхүүжилт 100 хувь хасагдаж 1778.3 сая төгрөгөөр батлагдсан байна.



2017 оны ОНХС-гийн орлогыг анх ИТХ-ын 2017 оны 3-р хуралдааны 3/02 тоот тогтоолоор сумдын ОНХС-д 921.4 сая, аймгийн ОНХС-д 1466.1 сая, бүгд 2387.5 сая төгрөгөөр баталсан. Мөн 2017 оны 4-р хуралдааны 02/3 тоот тогтоолоор сумдын ОНХС-д-д 921.4 сая төгрөг, аймгийн ОНХС-д 856.9 сая төгрөгөөр нийт 1778.3 сая төгрөгөөр тодотгол хийн аймгийн ОНХС-гийн төсвийг 609.2 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

Аймгийн ОНХС-д олгох шилжүүлгийг сангийн сайдын баталсан аргачлалын дагуу тооцож эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөсөн нь Сангийн сайдын 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.1³-дэх заалттай нийцэж байна.

ОНХНС-аас олгох шилжүүлэг, дансны үлдэгдэл, авлагын эргэн төлөлтөөс эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

¹ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно

² Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутагт хуваарилахдаа ашигт малтмалын олборлолт хийгдсэн тухайн орон нутгийн нэг хүнд ногдох хэмжээг бусад орон нутгийн нэг хүнд ногдох хэмжээнээс 10 хүртэл хувиар нэмэгдүүлэн тогтооно.

³ Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг ашиглан тухайн шатны орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дараахь байдлаар тооцож төлөвлөнө.

1.1.2 Тайлант онд ОНХНС-аас 1713.7 сая, “Тогтвортой амьжиргаа 3” төслөөс 64.6 сая, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 88.1 сая, авлагаас 214.7 сая нийт 2081.1 сая төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр ОНХНС-аас 1713.7 сая, “Тогтвортой амьжиргаа 3” төслөөс 64.6 сая, авлагаас 237.1 сая, давсан орлогоос 45.3 сая, нөхөн сэргээлтийн барьцаагаар 377.0 сая нийт 2437.7 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үенч сум нь 44.5 сая, Дуут сум нь 0.8 сая нийт 45.3 сая төгрөгийн давсан орлогыг ИТХ-ын шийдвэргүйгээр ОНХС-д төвлөрүүлсэн байна.

ОНХС-гийн хөрөнгийг сумдад Төсвийн тухай хуулийг баримтлан олгосон байна.

1.1.3 Аймгийн ОНХС-гаас сумдад олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59.2-т заасны дагуу хуваарилсан байна.

ОНХС-д 1778.3 сая төгрөгөөр батлагдсанаас 1713.7 сая төгрөгийн санхүүжилт ирж төсөл хөтөлбөрөөр 64.6 сая төгрөгийн санхүүжилт авч нийт батлагдсан төсвийг хуваарийн дагуу зарцуулаагүй байна. Засаг даргын баталсан хуваариас Мянгад суманд 5.0 сая төгрөг илүү, Зэрэг суманд 8.3 сая төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

Бүлэг 1.2: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй ажлыг баталж санхүүжүүлсэн, зарим ажлын гүйцэтгэл хангалтгүй, заавар журмыг мөрдөж ажиллаагүйгээс сангийн зарцуулалт үр дүн муутай байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс авах урьдчилсан жагсаалтыг гарган нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулаагүй, хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд нь үр дүнтэй болсон талаар ажлын тайлан мэдээ байхгүй байна.


1.2.1 Тайлант онд аймгийн ОНХС-д 264.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэлтэй байсан бол ОНХНС-аас 1778.3 сая төгрөгийн санхүүжилт төсөл хөтөлбөр бусад орлогоос 761.3 сая төгрөг нийт 2539,6 сая төгрөгийн орлого бүрдүүлж 2359.8 сая төгрөгийн зарлага санхүүжүүлж оны эцэст 444.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Аймгийн ОНХС-гийн эх үүсвэрээр нийт 175 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга төлөвлөснөөс 16 ажил нь өмнөх оны дутуу хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ 159 ажил нь шинээр эхлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ байна.

2017 онд аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр нийт 34 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан байна. Эдгээр 34 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 2 хөрөнгө оруулалт нь 2016 оны, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь шинээр эхлэхээр төлөвлөсөн байна.

Аймгийн хэмжээнд нийт төлөвлөсөн 175 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнээс 555.8 сая төгрөгийн 49 хөтөлбөрийг санхүүжүүлэхээр Аймаг болон сумын ИТХ төлөвлөн баталсан байна.

/График-2/

График-2-оос үзэхэд нийт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөрөөс 84 хувь буюу 467.4 сая төгрөгийн 24 хөтөлбөрийг аймагт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.



Аудитаар нийт 357 иргэдээс санал авч нэгтгэж дүгнэсэн. /График-3/ Санал асуулгаар таны баг хорооны Засаг дарга 2017 онд ОНХС-гийн хөрөнгөөр хамгийн трүүнд хийх шаардлагатай ажлуудын саналыг иргэдээс авах ажлыг зохион байгуулсан уу гэсэн асуултанд нийт хамрагдсан иргэдийн 51 хувь буюу 182 иргэн оролцсон, 15.7 хувь буюу 56 иргэн оролцоогүй, 33.3 хувь буюу 119 иргэн сайн мэдэхгүй байна гэж хариулсан байна.



Та нээлттэй хэлэлцүүлэгт оролцсон уу гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 41.7 хувь буюу 149 иргэн тийм, 58.3 хувь буюу 208 иргэн нь үгүй гэж хариулсан байна. Энэ нь ОНХС-гийн санхүүжилтээр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхөдөө иргэдийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх хөтөлбөрийг төлөвлөхдөө Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тогтоолыг мөрдөн ажиллаагүй байна. Тухайлбал:

- ✓ Сум дүүргийн иргэдийн саналыг авсан аймгийн чиг үүрэгт хамаарах саналын жагсаалтыг аваагүй байна.
- ✓ Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэний танхимаар иргэдээс санал аваагүй байна.
- ✓ Аймгийн Засаг дарга, ХОХБТХ нь дээрх тушаалын 6.7⁴ иргэдээс санал авахгүйгээр нийт төлөвлөсөн 34 ажлаа ИТХ-аар оруулж батлуулсан байна.
- ✓ 2017 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн үр дүнг дүгнэсэн ажлын тайлан мэдээ байхгүй байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний дийлэнх хувийг шууд гэрээ байгуулан санхүүжүүлсэн байна.

1.2.2 2017 онд аймаг сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 175 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагджээ. ОНХС-аас ирэх шилжүүлэг буурсан, зарим төсөл арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсонтойгоор холбоотойгоор Мөнххайрхан, Зэрэг сумуудад тус бүр 1 ажил хэрэгжээгүй нийт 173 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна. /График-4/

⁴ Аймгийн ИТХ нь аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний нэгдсэн саналыг төсөл тус бүрээр хэлэлцэн төсвийн төсөлд тусган “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоол/загвар маягт/-ын 3-р хавсралтын дагуу батлана.

/График-4/

Дээрх ажлуудын 1.7 хувь буюу 3 ажлыг НТШ-аар, 4.6хувь буюу 8 ажлыг харьцуулалтын аргаар, 93.6 хувь буюу 162 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд шууд гэрээ байгуулжээ. Худалдан авах ажиллагааг хүснэгтээр үзүүлбэл:



/Хүснэгт-1/

Ховд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын сонгон шалгаруулалт

№	Аймаг, сум, дүүргийн нэр	Төлөвлөсөн ажил				ХАА-ны журам					
		Өмнөх оноос шилжүүлсэн		Шинэ ажил		НТШ		ХА		ШГБ	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Манхан сум			16	76.9	0	0	1	37.5	15	39.4
2	Мөнххайрхан сум	1	4.5	7				1	15.3	6	32
3	Буянт сум	1	11.3	8	79.3			2	27.6	6	63
4	Буянт сум	3	7.8	7	39.3					10	47.1
5	Мянгад сум	1	2.7	4	25.7					5	28.4
6	Дуут сум	2	15.4	10	48.2					12	63.6
7	Зэрэг сум			7	62.1			0	0	6	44
8	Мөст сум	1	5	9	42.8					10	47.8
9	Ховд сум			5	84.9	1	40.8			4	54.1
10	Дарви сум			5	53					5	53
11	Булган сум			5	59.7					5	59.7
12	Дөргөн сум			8	48.2					8	46.2
13	Эрдэнэбүрэн сум	1	11.5	3	40.6					4	52.1
14	Алтай сум			14	61.7					14	61.3
15	Цэцэг сум			4	42.5					5	42.5
16	Үенч сум	2	15	7	74.2	0	0			9	89.2
17	Жаргалант сум	2	10	8	163.1					10	173.1
18	Ховд аймаг	2	212.3	32	947.3	2	535.9	4	180	28	443.7
	Аймгийн дүн	16	287.7	159	1949.5	3	576.7	8	245.1	162	1440.2

Дээрх хүснэгтээс харахад ТБОНӨХБАҮХА тухай хуулийг зөрчин дараа ажлуудад шууд гэрээ байгуулсан байна. Үүнд:

- ✓ *Үенч сум нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийг зөрчин босго үнээс давсан 44.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй трактор худалдан авах ажилд шууд гэрээ байгуулсан байгаад албан шаардлага өгөх*
- ✓ *Затус ХХК-тай засгийн газрын 2013 оны 68⁵-р тогтоолыг зөрчин шууд гэрээ байгуулан Хот тохижуулах газарт ковш трактор нийлүүлэхээр 38.0 сая төгрөг олгосон боловч гэрээгээ зөрчин хугацаандаа нийлүүлээгүй байгаад 2.5 сая төгрөгийн алданги тооцож акт бичиж 38.0 сая төгрөгийн албан шаардлага бичлээ.*

⁵ хавсралтын шууд худалдан авч болох босго үнээс давсан ажилд шууд гэрээ байгуулсан

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд захиалагчийн зүгээс хангалттай хяналт тавиагүй байна.

1.2.3 Аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар ИТХ-ын 2017 оны 4 дүгээр хуралдааны 02 тогтоолоор шилжих хөрөнгө оруулалтаар 101.5 сая төгрөг, тоног төхөөрөмж 200.8 сая төгрөг, их засвар 310.0 сая төгрөг хөтөлбөр төсөл арга хэмжээнд 467.3 сая төгрөг, ИХТ-ийг чадавхжуулах 80.0 сая төгрөг, нийт 34 ажлын 1159.6 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулахаар баталсан байна.

Батлагдсан төсвөөс урьд оноос шилжиж ирсэн концессын гэрээгээр хийх ажил болох Баатархайрхан өрхийн эмнэлгийн барилга 35.0 сая төгрөг, Галданбошгит хааны гудамжны тохижуулалтад 30.0 сая төгрөг, ТОСК-ийн гадна шугам сүлжээний ашиглалтад 200.8 сая төгрөг, 2017 оны Жаргалант сумын 11-р цэцэрлэгийн их засварт 200.0 сая төгрөг зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажилд зарцуулсан байна.



Аймгийн дулааны хуучирч муудсан шугам засах, нийтийн орц гадна тохижилт хийх, хэрэглээний халуун ус засварлахад 110.0 сая төгрөг, зураг төсвийн урьдчилгаа 211.8 сая төгрөг зарцуулж актаар хүлээн авсан байна. Мөн аймгийн батлагдсан төсвийн 47,2 хувь нь хөтөлбөр арга хэмжээнд төсөвлөгдсөнөөс иргэдийн танхим, уулзалтын өрөөг засварлах, тоног төхөөрөмж авахад 30.0 сая төгрөг, бусад хөтөлбөр арга хэмжээний зардалд 517.3 сая төгрөг зарцуулжээ.



Аймгийн ИТХ-аар нийт 34 төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлэхээс багийн эмч нарыг унаажуулах 1 ажил хийгдээгүй бусад 33 ажлын 2 ажил урьд оны дутуу санхүүжилт бусад 24 ажил хөтөлбөр арга хэмжээнд зарцуулагдсан байгаа бөгөөд иргэдийн нийтийн санал аваагүй зарим төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46-р зүйлийн 46.1.6^б-д заасан явцын хяналтыг хэрэгжүүлээгүй, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулагдаж байгаа хөрөнгийн үр дүн төдийлөн харагдахгүй байна. Тухайлбал:

- ✓ *Аймгийн ИТХ-аар нутгийн өөрөө удирдах байгууллагыг чадавхжуулах хөтөлбөр, Тунгалаг бүртгэл хөтөлбөр, сургууль хүний хөгжлийн дэд хөтөлбөр, хүүхэд бүр цэцэрлэгт хөтөлбөр, жендерийн тэгш байдлыг хангах хөтөлбөр, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хөтөлбөр, гэр бүлийг дэмжих хөтөлбөр зэрэг 16 хөтөлбөр, уулзалтын өрөөг тохижуулах, тавилга эд хогшил авах зэрэг төсөв баталж хэрэгжүүлж байна. Дээрх хөтөлбөрийн хэрэгжилтэд 2017 онд 325.8 сая төгрөг баталж 265.8 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Энэ нь Сангийн сайдын ОНХС-гийн 2014 оны 43 тоот тушаалын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын чиглэлтэй нийцэхгүй байна. ОНХС-гийн хөрөнгөөр нийтийг*

^б Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих

- хамарсан, олон нийтийн саналаар эрэмбэлэгдсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх ёстой байтал хэтэрхий жижиглэсэн хөтөлбөр арга хэмжээнд үр дүн багатай зарцуулсан,
- ✓ Засаг даргын нөөц хөрөнгөөс өвсний нөөц бүрдүүлэх ажлыг аймгийн ОНХС-аас бэлтгэж 5.3 сая төгрөг санхүүжүүлсэн байгаа нь өмнөх аудитаар өгөөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй,
 - ✓ ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах хөтөлбөрт 80.0 сая төгрөгийг баталж гадаад томилолтод 42.3 сая төгрөг, ой арга хэмжээний зардалд 25.5 сая төгрөг, тавилга тоног төхөөрөмж худалдан авахад 12.2 сая төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60.3.6⁷-д заасан заалтыг хэрэгжүүлээгүй арга хэмжээ санхүүжүүлэхийг хориглосон заалтыг зөрчсөн, МУИХ-ын 2016 оны 47⁸ тоот тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй,
 - ✓ Засаг даргын хурлын заал, иргэний танхимын засвар, тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулах хөрөнгийг төлөвлөсөн зардлаас 15.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, батлагдсан төсвийн хэмжээнд зардал гаргаагүй байгаа нь төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.5⁹-дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй ОНХС-гийн хөрөнгөөр тавилга эд хогшил худалдан авч байгаа нь Сангийн сайдын ОНХС-гийн 2014 оны 43 тоот тушаалын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын чиглэлтэй нийцэхгүй байна.
 - ✓ Тулгат багана ХХК-нь Жаргалант сумын 11-р цэцэрлэгийн их засварын ажлыг дутуу хийсэн, хугацаандаа хүлээлгэж өгөөгүй, хяналтын зардал дутуу суутгаж авсан, магадалшгүй ажлын төсвөөр хийгдсэн ажлын акт дутуу, зарим цахилгааны утас холболт шаардлага хангахгүй, угаалгын өрөө, хүүхдийн ариун цэврийн өрөөний шал стандарт бус, аюулгүй орчин бүрдээгүй, цэцэрлэгийн хөрөнгөд бүртгэлтэй хуучин дээврийн төмөр, халаалтын системүүдийг солиод хүлээлгэж өгөөгүй байгаад 0.7 сая төгрөгийн алданги, хяналтын зардал дутуу суутгасан 2.9 сая төгрөг нийт 3.6 сая төгрөгийн акт, хөрөнгө буцааж хүлээлгэн өгөөгүй дээврийн төмөр 0.6 сая төгрөг, халаалтын паарны үнэ 2.4 сая төгрөг нийт 3.1 сая төгрөгийн акт бичих
 - ✓ Тунгалаг хөтөлбөр бүртгэлийн хүрээнд хэрэгжсэн хөтөлбөрийг хувийн харилцаагаар дамжуулан зарцуулсан, босго үнээс давсан хөрөнгө бэлтгэхдээ засгийн газрын тогтоол шийдвэр зөрчсөн, төсвийн байгууллагын мөнгөн кассын журмыг зөрчсөн 21.9 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6¹⁰-дахь заалт, Засгийн газрын 2013 оны 68¹¹ дугаар заалттай нийцэхгүй байна.
 - ✓ Хөтөлбөр арга хэмжээнд зарцуулагдахаар төлөвлөсөн зардлыг ЗДТГ-ын мэргэжилтэн болон бусад хувь хүний харилцах дансаар дамжуулан олгосон

⁷ Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно

⁸ Албан ажлын зайлшгүй шаардлага гарч, дээд шатны удирдах байгууллага, албан тушаалтны албан ёсоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд гадаад томилолтын зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх

⁹ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

¹⁰ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ,

¹¹ тогтоолын хавсралтын шууд худалдан авч болох босго үнээс давсан ажилд шууд гэрээ байгуулсан

байгаа нь хэрэгжүүлсэн ажлын анхан шатны баримтын бүрдэл дутуу, ажлын тайлан байхгүй, төсөвт байгууллагын мөнгөн кассын журмын 3-р зүйлийн 3.2¹²-д заасныг зөрчсөн байгаа 17.4 сая төгрөгийн зөрчил илэрч хөтөлбөр арга хэмжээг үр дүнгүй зарцуулсан байна.

- ✓ ИТХ-аар хөрөнгө оруулалтын хөтөлбөр арга хэмжээнд батлагдаагүй ОНХС-гаас олгож байгаа Хот тохижуулах газрын санхүүжилт болох 112.2 сая төгрөгийг батлагдсан төсвийн дагуу зарцуулах цаашид ямар журмаар зохицуулагдаж явахыг шийдвэрлэх шаардлагатай,
- ✓ Галдан бошигт хааны гудамж, Баатархайрхан багийн өрхийн эмнэлгийн барилга, ТОСК-ын гадна шугам сүлжээний ажил болох ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгийг орлогод авч данс бүртгэлд тусгаагүй 1115.3 сая төгрөгийн хөрөнгө орлого аваагүй хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлыг хүлээлцэх явцдаа хөрөнгө бүртгэх ажлын хэсгийг зохион байгуулж ажиллаагүй,

Жаргалант сумын ОНХС-гийн ажлын гүйцэтгэл хангалтгүй, ОНХС-гийн заавар журмыг хэрэгжүүлж ажиллаагүй, авлага үндэслэлгүй бууруулсан, босго үнээс давсан ажлуудыг шууд гэрээ байгуулан ажилласан байна.

1.2.4 Жаргалант сумын ИТХ-ын 2-р хуралдааны 2016/12/16-ны 2/05 тоот тогтоолоор 2017 онд 66,7 сая төгрөг, 2017 онд ИТХ-ын 2017/12/22-ны 01 тоот тогтоолоор 377.5 сая төгрөг 2018/10/22-ны 02 тоот тогтоолоор 145.2 сая төгрөг тодотгож нийт 522.7 сая төгрөг зарцуулахаар баталсан байна. 2017 онд шилжих хөрөнгөөр 10.0 сая төгрөг, тоног төхөөрөмж авах 2.0 сая төгрөг, ИХТ-нарыг чадавхжуулах 10.0 сая төгрөг, МЭУС зардалд 25.4 сая төгрөг, хөтөлбөр арга хэмжээний зардалд 19.3 сая төгрөг зарцуулсан бол 2018 оны 10-н сарын байдлаар шилжих хөрөнгөөр 23.9 сая төгрөг, тоног төхөөрөмж авахад 87.3 сая төгрөг, хөтөлбөр арга хэмжээний зардалд 165.8 сая төгрөг баталснаас тодотголоор их засварт 55.0 сая төгрөг, тоног төхөөрөмж авахад 30.0 сая төгрөг, хөрөнгө оруулалтын 50.0 сая төгрөг хөтөлбөр арга хэмжээнд 10.0 сая төгрөг нэмж баталсан байна.

Жаргалант сумын ИТХ-аар 2017 онд 8 төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлснээс ногоон байгууламж хийх ажлыг хэрэгжүүлээгүй зардлын 5.0 сая төгрөгөөр ЗДТГ-ын шинээр баригдах барилгын зураг төсөв хийлгэсэн, 2018 онд 39 ажил төлөвлөгдсөнөөс хүлээн авсан актаар баталгаажсан 19 ажил, гүйцэтгэлийн шатанд 17 ажил, эхлээгүй байгаа 3 ажил байна. Аймгийн засаг даргын эрх шилжүүлсэн 3 ажил болох бульдозер, ковш, толгойн барилгын засварын ажлыг босго үнийг давсан байхад шууд гэрээ байгуулсан, тендерийн бичиг баримтыг өөрчилсөн байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.7¹³-д заалт, 41 дүгээр зүйлийн 41.1.1¹⁴-д заасан заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- ✓ ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах хөтөлбөрт 27.5 сая төгрөгийг баталснаас гадаад томилолтод 7.5 сая төгрөг дотоод танилцах,

¹² Мөнгөн кассын гүйлгээг байгууллагын төсвийн эрх захирагчийн тушаал, шийдвэрээр томилогдсон мөнгөн кассын нярав хариуцан гүйцэтгэнэ

¹³ "хууль, гэрээнд зааснаас бусад тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулахгүй байх"

¹⁴ захиалагч урьдчилан харах нөхцөл боломжгүй байдал үүссэний улмаас гэрээнд зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийхээс бусад тохиолдолд тендерийн агууллагатай холбоотой гэрээний нөхцлүүдийг өөрчлөхийг хориглоно

туршилага судлах аяллын зардалд 15.1 сая төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60.3.6¹⁵-д заасан заалтыг хэрэгжүүлээгүй арга хэмжээ санхүүжүүлэхийг хориглосон заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй,

- ✓ Хөтөлбөр арга хэмжээний зардлыг хувийн харилцах данс руу шилжүүлэн анхан шатны баримтгүй, баримтын бүрдэл дутуу, урсгал зардалд зарцуулсан нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.7¹⁶-д заасан хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй 5.2 сая төгрөгийн зөрчилд дахин давтахгүй байх зөрчсөн,
- ✓ Сангийн хэрмийн археологийн малтлагын ажилд Баруун бүс нутаг судлалын НҮТББ байгууллага гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч ямар үр дүнд хүрэх тооцоо судалгаа дүгнэлт гараагүй, ажлын явцын хяналт хийсэн мэргэжлийн байгууллагын тайлан байхгүй, захиалагчийн хяналт хийгдээгүй 8.0 сая төгрөгийн зөрчилд дахин хянах ажлын гүйцэтгэл гаргаж малтлагаас гарсан олдворыг Жаргалант суманд хүлээлгэн өгөх, хүлээн авсан актаар баталгаажуулах, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй,
- ✓ Жаргалант ойн төгөл ХХК-д утаагүй зуухны туршилт гэсэн 5 зуухны 1.7 сая төгрөг шилжүүлсэн нь эргэн тооцох гэрээ хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй орлого аваагүй, хэнд өгсөн нь тодорхойгүй байгаад буцаан төлүүлэх акт бичлээ. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.
- ✓ Ньюбл Даймонд ХХК-нь ХОАЖСЗДТГ/ХТ/20180019 гэсэн гэрээгээр хот тохижуулах газарт ногоон байгууламжийн усалгааны хэрэгцээнд усны машин нийлүүлэхээр шалгарсан боловч тендерийн техникийн нөхцөл өөрчилсөн, зориулалт бус, шаардлага хангахгүй бохирын машин нийлүүлсэн, мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүй, хүлээн авсан комисс хяналтаа хэрэгжүүлж ажиллаагүй байгаад 29.8 сая төгрөгийн акт бичиж дахин шалгуулахаар хуулийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46-р зүйлийн 46.1.7¹⁷-р заалт, 41-р зүйлийн 41.1.1¹⁸ дэх заалтыг зөрчсөн байна.
- ✓ Жаргалант сумын сургууль цэцэрлэгийн засвар, тохижилт үйлчилгээнд Цаст Алтай цогцолбор сургууль 10.0 сая төгрөг 9-р цэцэрлэг 3.0 сая төгрөгөөр тоглоомын талбай хийсэн нь ажлын гүйцэтгэл дутуу, сургуулийн гадна талын жорлон, хүүхдийн амрах саравч, гадна хаалга чанарын шаардлага хангахгүй хэт өндөр үнэтэй байгаа 12.1 сая төгрөгийн зөрчилд дахин сайжруулах, нэмэлт ажлуудыг хийж актаар баталгаажуулах албан



¹⁵ Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно

¹⁶ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно",

¹⁷ хууль, гэрээнд зааснаас бусад тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулахгүй байх"

¹⁸ захиалагч урьдчилан харах нөхцөл боломжгүй байдал үүссэний улмаас гэрээнд зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийхээс бусад тохиолдолд тендерийн агууллагатай холбоотой гэрээний нөхцлүүдийг өөрчлөхийг хориглоно

шаардлага бичлээ. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6¹⁹-дэх заалт, ОНХС-ийн заавар журмын 11-р зүйлийн 11.2.2²⁰-дэх заалттай нийцэхгүй байна.

- ✓ Ногоон алтай ХХК-нь ТШ-2018-ажил-08/29-11 тоот гэрээг байгуулан Хот тохижуулах газрын граж барих ажлыг гүйцэтгэхээр 5.3 сая төгрөгийн санхүүжилт аваад ажлаа гэрээнд заасан хугацаандаа хийж өгөөгүй байгаад 0.3 сая төгрөгийн алданги тооцож 5.3 сая төгрөгийн дутуу ажлыг хугацаа заан гүйцэд хийлгэн хүлээн авсан актаар баталгаажуулах албан шаардлага өгөх. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.1²¹-дахь заалттай нийцэхгүй байна.
- ✓ Аймгаас Жаргалант суманд зарцуулах эрх шилжүүлсэн бульдозер нийлүүлэх ХОАЖСДТГ/201801022 тоот гэрээг ГЦЦЭ ХХК-тай хийж 2018 оны 07-р сарын 30-ны дотор нийлүүлж ашиглалтад өгөхөөр харилцан тохиролцсон боловч гэрээгээ зөрчин хугацаандаа нийлүүлээгүй 2.9 сая төгрөгийн алданги тооцож акт бичих, 75.0 сая төгрөгийг гэрээний дагуу шаардсан шаардлагад нийцсэн техникийг нийлүүлэх албан шаардлага бичлээ. Энэ нь Засгийн газрын 2013 оны 68²²-дугаар тогтоол, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6-дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй,
- ✓ Аймгаас Жаргалант суманд эрх шилжүүлсэн хотын ногоон байгууламж хийх ТШ-2018040507 тоот харьцуулалтын аргаар Тэгш стандарт ХХК-тай хийсэн гэрээний дагуу тус байгууллага нь Жаргалант суманд гоёлын мод, зүлэг нийлүүлсэн гэх боловч хаана орлого авсан, тараасан баримт байхгүй, ажлын явцын хяналт хийгээгүй 10.0 сая төгрөгийн ажлыг дахин хянаж дутуу ажлуудыг хийлгэн актаар баталгаажуулах, дутуу санхүүжилтийг ажлаа гүйцэд хийтэл олгохгүй байх албан шаардлага бичих. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.7²³-дахь заалт, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6²⁴-дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй
- ✓ Аймгаас Жаргалант суманд эрх шилжүүлсэн Бугат үзүүрийн толгойн барилга засах ажлын зарцуулалтын баримт байхгүй, явцын хяналт хийгдээгүй, хийсэн ажлын тайлан баримтгүй 12.0 сая төгрөгийн ажлыг тухайн Хот тохижуулах газраар зураг төсвийн дагуу бүрэн хийлгэж актаар баталгаажуулах, ажлаа бүрэн хийсэн тухайд дараагийн санхүүжилт олгох албан шаардлага бичих. Энэ нь Нягтлан бодох



¹⁹ Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих"

²⁰ ОНХС-ийн санхүүжилтийн нээсэн эрхийг үндэслэн тухайн орон нутаг төсвийн санхүүжилт хийдэг албан тушаалтнууд зохих журмын дагуу хянаж гүйлгээг хийнэ"

²¹ Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах",

²² тогтоолын хавсралтын шууд худалдан авч болох босго үнээс давсан ажилд шууд гэрээ байгуулсан,

²³ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно

²⁴ Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих

бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.7²⁵-дахь заалт, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6²⁶-дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй

- ✓ Иргэн С.Даваасамбуугийн хувь оролцоотой халуун усны барилгыг ОНХС-гаас 2015 онд 44.0 сая төгрөгөөр хийсэн бөгөөд 2017 онд Жаргалант сумын хөрөнгөд бүртгээсэн байна. Орон нутгийн өмчид бүртгэлтэй дээрх хөрөнгийг хувь хүн ямар нэгэн төлбөргүйгээр эзэмшиж орлого олж байгаа зөрчил илэрсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6²⁷-дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.4²⁸-дэхь заалттай нийцэхгүй байна. Дээрхи зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх.

Жаргалант сумаас бусад сумуудын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээ нь зохих түвшинд хэрэгжсэн байна.

1.2.5 Буянт, Булган, Дуут, Мөнххайрхан, Зэрэг сумууд нь ОНХС-гийн хөрөнгийг томоохон бүтээн байгуулалтын ажилд зарцуулсан байна. Жишээлбэл:

- ✓ Мөнххайрхан сумын гудамж төсөл, гэрэлтүүлгийн ажлууд хийж үр шимийг хүртэж гэрэлтүүлэгтэй сум болсон,
- ✓ Булган сум нь ОНХС-гийн хөрөнгөөр хог хаягдлын цэг байгуулах, иргэдийн санал санаачилгад тулгуурласан ажлаар гудамжаа камержуулсан, нийтийн эзэмшлийн зам засаж иргэдийн ая тухтай амьдрах орчин бүрдүүлсэн,
- ✓ Алтай, Буянт, Зэрэг, Чандмань сумууд нь мал угаалгын ванн барьж ашиглалтад оруулсан нь хөдөөгийн малчдад малаа эрүүл өсгөх нөөц боломжийг бүрдүүлсэн,
- ✓ Буянт сум хөдөөгийн баг болон сумын төвийн багт худаг гаргаж сумын төвийн хашааны хаягжуулалтын ажил хийсэн,

Гэвч зарим цөөн сумууд нь ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг орлогод аваагүй, иргэдийн санал санаачилга аваагүй ажлуудыг санхүүжүүлсэн байна. Тухайлбал:

- ✓ Манхан сум нь 4.4 сая төгрөгийг 2017 онд багуудад зөвөрийн усны авто машины үнэд шилжүүлсэн боловч авлагаар бүртгээгүй тухайн авто машин нь тайлант онд багтаж ирээгүй тул мөнгөн хөрөнгийг буцаан төвлөрүүлэх зөвлөмж өгч зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна. Мөн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн ковш трактор, халаалтын тогоо зэрэг нийт 44.5 сая төгрөгийн хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгах зөвлөмжийг СТА-аар өгсөн байхад хэрэгжүүлээгүй тул албан шаардлага бичлээ.
- ✓ Дуут сум нь 29.9 сая төгрөгийн өртөгтэй багийн төвийн их засварын ажлыг данс бүртгэлд тусгаагүй өглөгийг тайлан балансад тусгаагүй,
- ✓ Цэцэг сум нь ОНХС-гийн хөрөнгөөр сумын ерөнхий төлөвлөгөө гаргуулахаар 8.0 сая төгрөгийн гэрээ байгуулж 2.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч ажил хийгдээгүй тул Шүүхийн байгууллагад

²⁵ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно

²⁶ Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих

²⁷ Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах

²⁸ төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх

хандсан байна. Мөн Иргэдийн санал санаачилгад тусгагдаагүй ИТХ-аар батлуулаагүй Майдар залах ёслолд 4.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

- ✓ Үенч сум нь ОНХС-гийн хөрөнгөөр ИТХ-аар батлуулаагүй 2.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсантай холбоотойгоор төлбөрийн акт тавигдсан байна. ИТХ-аар батлуулаагүй, ТБОНӨХБАҮХА тухай хуулийг зөрчин босго үнээс давсан трактор худалдан авах ажилд шууд гэрээ байгуулсан 44.5 сая төгрөг, 11.4 сая төгрөгийн ажилд захиалагчийн хяналт тавиагүй, хүлээн авсан актаар баталгаажуулаагүй ажлууд, ахуй үйлчилгээний засварт 10.0 сая төгрөг зарцуулсан зэрэг зөрчлүүд байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн зураг төсвийн зардлыг тооцоо хийж баталгаажуулаагүй, он дамжин удааширсан авлага ихтэй, зарим зураг төсөв байхгүй байна.

1.2.6 Санхүүгийн тайлангийн аудитаар ОНХС-гийн авлага Булган суманд 71.1 сая төгрөг, Буянт суманд 26.2 сая төгрөг, Жаргаланд суманд 244.8 сая төгрөг, Зэрэг суманд 8.2 сая төгрөг, аймгийн ОНХС-д 1034.2 сая төгрөгийн авлага тус тус оны эцэст үлдэгдэлтэй тайлагнасан байна. Нийт 5 суманд 350.3 сая төгрөг аймагт 1034.1 сая төгрөг нийт 1384,4 сая төгрөгийн авлага үлдэгдэлтэй тайлагнасан байгаа нь тендер, төсөл, гэрээгээр шалгарсан аж ахуйн нэгж байгууллагууд ажлаа дутуу хийсэн, хүлээлгэж өгөөгүй, огт хийгээгүй зэрэг гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүй байна. Аймгийн хэмжээний авлагыг хүснэгтээр харуулбал: /Хүснэгт-2/

ОНХСангийн 2017 оны авлага				
Төсөв захирагч	Өмнөх он	Нэмэгдсэн	Хорогдсон	Тайлант он
Булган	71.6		0.5	71.1
Буянт	41.2		15.0	26.2
Жаргалант	562.7		317.8	244.8
Зэрэг		8.2		8.2
Аймаг ОНХСан	1,091.4	206.8	264.1	1,034.2
Нийт дүн	1,766.9	215.0	597.4	1,384.5

Дээрх хүснэгтээс харахад авлагын эхний үлдэгдэл 1,7 тэрбум төгрөг байснаас 215,0 сая төгрөгөөр нэмэгдэж 597,4 сая төгрөгөөр хасагдаж 1384,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8²⁹-д заасан заалтыг хэрэгжүүлж

ажиллаагүй авлагын дийлэнх хувь нь аймгийн ОНХС-гийн авлага байна.

Аймгийн ОНХС-гийн авлага 1034,1 сая төгрөг байгаагаас Долчим ХХК нөөцийн мах бэлтгэх 70,0 сая төгрөг, Жишиг хашаа барих 100,0 сая төгрөг, Алтайн буйлааст ХХК-аас 14.5 сая төгрөг, БИСЭТ ХХК-аас 20,0 сая төгрөг, Нөөцийн мах бэлтгэх 15,0 сая төгрөг, ХХААГ-аас өвсний үнэ 35,2 сая төгрөг гэх мэт 16 аж нэгж компаниудтай холбоотой авлагуудыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.5³⁰-д заасантай нийцэхгүй байна.

Аймгийн ОНХС-гийн авлага төдийлөн буурахгүй он дамжиж удааширсан авлага ихтэй байгааг хүснэгтээр харуулбал:

²⁹ Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх

³⁰ Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах

Хүснэгт-3/

ОНХСангийн авлага 2014-2018 оноор харуулбал						
Байгууллага	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл	Зориулалт	Хамрагдсан он
ЦЭЭО ХХК	35.0			35.0	Жишиг хашаа	2013
Ногоон Алтай ХХК	30.0			30.0	Жишиг хашаа	2013
Цогтбарс ХХК	35.0			35.0	Жишиг хашаа	2013
Ховд-Өнөрбүл ХХК	67.5		67.5	-	Нөөцийн мах	2013
Гэрэлт сэнж ХХК	67.5		67.5	-	Нөөцийн мах	2013
Зураг төсөв	308.7	517.5	71.4	754.8	Зураг төсөв	2013-2018
Эзэн холбогдогчгүй	7.6			7.6	Эзэн холбогдогчгүй	2013
ХХААГ	52.0		16.7	35.3	Өвсний нөөц	2013
ББМЗЗТ ХХК	30.0		30.0	-	Мөнххайрхан НУО	2013
Ховд Өнөр бүл ХХК		11.0	11.0	-	Нөөцийн мах	2014
Амгалан Ховд ХХК		15.0		15.0	Нөөцийн мах	2014
БМИнтернейшнль ХХК		70.0	70.0	-	Нөөцийн мах	2014
Долчим ХХК		70.0		70.0	Нөөцийн мах	2014
Алтайн буйлааст ХХК		30.0	15.5	14.5	Зэргийн санхүүжилт	2014
П.Ичинхорлоо		1.6	1.6	-	Булаг тохижуулах	2015
Цагаан тэмээт ХХК		3.2	3.2	-	Булаг тохижуулах	2015
ПН80121811		0.8	0.8	-	Булаг тохижуулах	2015
ЗХ-ний 123-р анги		5.8	5.8	-	Засвар	2015
Эко Ховд ХХК		12.5	12.5	-	Өвсний нөөц	2016
БИСЕТ ХХК		20.0		20.0	Дараа тооцоо	2016
Дабль сервис ХХК		90.0	90.0	-	Концесс	2016
Аймгийн хөгжлийн сан		5.0		5.0	ЗХЗардал	2016
Буянт тэгш үйлс ХХК		0.5		0.5	ЗХЗардал	2016
Оож өргөө ХХК		6.3	3.0	3.3	ЗХЗардал	2016
Нандинцэнгэл ХХК		1.5		1.5	ЗХЗардал	2016
Ирмүүн аргамаг ХХК		0.8		0.8	ЗХЗардал	2016
Оож өргөө ХХК		1.2		1.2	Акт	2016
Нур афра ББН		0.5		0.5	Акт	2016
Ховдын мэдээ сонин		1.6		1.6	Акт	2016
Ховд Их Сургууль		2.4		2.4	Акт	2016
Нью терравокс ХХК		0.2		0.2	Акт	2016
Нийт дүн	633.3	867.4	466.5	1,034.2		

ОНХС-гийн хөрөнгөөр хийх ажил дутуу хийгдсэн, хийсэн ажлаа хүлээлгэн өгөөгүй, хугацаандаа хийгээгүй, огт ажлаа эхлээгүй зэрэг авлагууд авлага буурахгүй байх гол шалтгаан болж байгаа, зураг төсөв нь урьдчилж хийгдсэн 754.5 сая төгрөгийн зураг төсвийн авлага нь ажлын санхүүжилт батлагдаагүй гэсэн шалтгаанаар хүлээгдэж байгаа зэрэг авлагатай холбоотой дараах дутагдлууд байна. Тухайлбал:

- ✓ Эгэл зураг ХХ-тай ТИТЭМ цогцолборын зураг төсөв хийлгэхээр 75.0 сая төгрөгийн гэрээ хийн урьдчилгаа 30.2 сая төгрөгийн санхүүжилт өгсөн боловч зургийн төсөв хийгдсэн зураг урьдчилсан байдлаар ирсэн гэсэн тайлбартай эх зураг төсөв хүлээж аваагүй байгаад алданги 3.0 сая төгрөг тооцож акт бичих, зураг төсөв хүлээлгэж өгөх 75.0 сая төгрөгийн албан шаардлага, авсан санхүүжилтийн тооцоо хийж авлага баталгаажуулах зөвлөмж өгөх
- ✓ UDC GROUP LLC ХХК-тай цэцэрлэгт хүрээлэнгийн зураг төсөв, тугны өндөрлөгийн зураг төсөв хийлгэхээр гэрээ байгуулсан боловч хүлээн авсан актаар баталгаажаагүй, зураг төсвийн төсөв байгаа зураг эх хувиар ирээгүй байгаа 2.9 сая төгрөгийн алданги тооцож, тугны зураг төсөв ирүүлээгүй 9.8 сая төгрөгийн акт, цэцэрлэгт хүрээлэнгийн зураг төсөв хүлээлгэж өгөх 49.0 сая төгрөгийн албан шаардлага бичих

- ✓ Зураг төсөв нь олдохгүй байгаа хүлээж авсан хүлээлгэж өгсөн актаар баталгаажуулаагүй, авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй ББМЗЗТ-ХХК-ны 10.8 сая төгрөг, Алтайн газрын хүч ХХК-ны 23.3 сая төгрөг, Мөнхийн тод зам ХХК-ны 15.0 сая төгрөг, Кон-Инженерес ХХК-ны 65.0 сая төгрөг, Билгүүн шонхор ХХК-ны 15.0 сая төгрөг гэх мэт нийт 210.9 сая төгрөгтэй холбоотой авлагыг барагдуулах хуулийн байгууллагад шилжүүлэх
- ✓ ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн эргэн төлөгдөх нөхцөлтэй ЦЭО ХХК-ны 35.0 сая төгрөг, Ногоон-Алтай ХХК-ны 30.0 сая төгрөг, Цогт барс ХХК-ны 35.0 сая төгрөг нийт 100.0 сая төгрөгийн өртөг бүхий жишиг хашаа барих ажлаа бүрэн хийгээгүй байгаад 12.3 сая төгрөгийн алданги тооцож хуулийн байгууллагад шилжүүлэх
- ✓ ОНХС-гийн хөрөнгөөс нөөцийн мах бэлтгэхээр Амгалан ховд ХХК-нь 15.0 сая төгрөг, Долчим ХХК-нь 70.0 сая төгрөг нийт 85.0 сая төгрөгийн санхүүжилт аваад махаа нийлүүлээгүй байна. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг дагуу хуулийн байгууллагад шилжүүлж, шүүхийн шийдвэр гарсан ч одоог хүртэл барагдаагүй байна.
- ✓ Авлагын тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй эзэн холбогдогч нь тогтоогдохгүй байгаа 7.6 сая төгрөг, ХХААГ-ын өвсний нөөц бүрдүүлээгүй 35.3 сая төгрөг, Алтайн буйлааст ХХК-ны санхүүжилт илүү авсан 14.5 сая төгрөг, БИСЕТ ХХК-ны дараа тооцоогоор гэсэн 20.0 сая төгрөг, хяналтын зардал суутгаж аваагүй болон бусад 17.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах акт тогтоож хуулийн байгууллагад шилжүүлэх

Жаргалант суманд 2013 оноос хойш авлага тооцож үзэхэд эхний үлдэгдэл 4.8 сая төгрөг эцсийн үлдэгдэл 240.4 сая төгрөг байна. Жаргалант сумын нийт авлагыг хүснэгтээр харуулбал: /Хүснэгт-4/

Жаргалант сумын ОНХСангийн авлага 2014-2018 оноор харуулбал						
Байгууллага	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл	Зориулалт	Хамрагдсан он
Хаягжуулалт/Рашаант, Наран иргэн Даваасамбуу	4.8		4.8	-	Багийн хаягжуулалт	2013
Атилла конштракшнь ХХК		44.0		44.0	Халуун ус эмийн сан	2014
Алдархишиг Буянт ИБ		44.8		44.8	Жишиг гудамж тохиж	2014
ИСЭТ ХХК		20.0	20.0	-	Тоглоомын талбай	2014
Гранд пасикал ХХК		0.06		0.06	Трансформатор	2014
Малчин түнш тавилга ХХК		3.0		3.0	Зам сайжруулах	2014
Бунжаргал /Эрчлүүр/		3.0		3.0	Жаргалант баг сүүдрэвч	2014
Оож өргөө ХХК		5.1	5.1	-	Хаягжуулалт	2014
Оож өргөө ХХК		10.0	10.0	-	Наран баг тоглоомын S	2014
Оож өргөө ХХК		18.0	18.0	-	Гэрэлтүүлэг	2014
Ланз ХХК		59.9	59.9	-	Явган хүний зам	2015
Мянган орд ХХК		2.5	2.5	-	Цаст Алтай БЗГазар	2015
Улам дэлгэрэх ББН		10.0	10.0	-	Ховд суварга НБ	2015
Д.Баатаржав Наран ИБ		3.0	3.0	-	2-р сургууль ДБДЗасвар	2015

Шинэ төгс шийдэл ХХК	17.2	17.2	-	ХЗСАХ-ийн тохижилт	2016
Ирмүүн аргамаг ХХК	136.5		136.5	Наран хороолол агаарын трай	2016
Иргэн С.Батмөнх	3.8	3.8	-	Магсаржав баг ОСТОхижилт	2016
Оож өргөө ХХК	24.7	24.7	-	Явган хүний зам	2016
Эвлэл ХХК	29.2	29.2	-	Шинэ хороолол худаг гаргах	2016
Оллсолюшн ХХК	17.4	17.4	-	Аюулгүй байдлын үнэлгээ хv	2016
Лакширизонне	14.4	14.4	-	МЭ-ийн тасаг арга хэмжээ	2016
Хүндэт тэмдэг	3.0	3.0	-		2016
Ховд Маралгуа ХХК	4.6		4.6	Ундны усны АБ-ыг хангах	2016
Гулзатын шил ХХК	25.7	25.7	-	Гэрэлтүүлэг	2016
Б.Лхагвасүрэн	12.4	12.4	-	Гэрэлтүүлэг	2016
Б.Аюурзана	10.0	10.0	-	Тоглоомын талбай	2016
Л.Мягмар	12.5	12.5	-	Гэрэлтүүлэг	2016
Акт төлбөр	4.5		4.5	Акт	2016
Ховд эрч хүч ХХК /УДТөгө	12.0	12.0	-	Ногоон байгууламж	2016
Ахмадын хороо	1.2	1.2	-	Сандал нийлүүлэх	2016
Ховд Өнөр бүл ХХК	13.3	13.3	-	Ундны усны АБ-ыг хангах	2016
Нийт дүн	4.8	565.8	330.1	240.5	

Дээрх авлагаас харахад Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.4³¹-дахь заалт, ОНХС-гийн заавар журмын 11-р зүйлийн 11.2.2³²-дахь заалт, Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8³³-дахь заалтыг хэрэгжилт хангалтгүй байгаа иргэн Б.Лхагвацэрэн Алагтолгой багийн гэрэлтүүлгийн ажил 23.1 сая төгрөг, иргэн Л.Мягмар Баатархайрхан багийн гэрэлтүүлгийн ажил 12.5 сая төгрөг, иргэн Б.Аюурзана Тахилт багийн тоглоомын талбай 10.0 сая төгрөг, Эко Ховд ХХК Жаргалант сумын хүндэт тэмдэг 3.0 сая төгрөг, Гулзатын шил ХХК Наран, Рашаант багийн гэрэлтүүлэг 25.6 сая төгрөг, Эвлэл ХХК Мандах наран хорооллын бүсэд инженерийн худаг барих 29.1 сая төгрөг, Ирмүүн аргамаг ХХК Мандах наран хорооллын агаарын цахилгаан дамжуулах шугам 136.5 сая төгрөг, Ховд өнөр бүл ХХК орон сууцны ундны усны аюулгүй байдлыг хангах 18.0 сая төгрөг, Шинэ төгс шийдэл ХХК залуучуудын соёл амралтын хүрээлэнгийн тохижилт хийх зэрэг 17.1 сая төгрөгийн авлага тус тус буурсан харагдаж байгаа боловч ажлаа гүйцэд хийж хүлээлгэж өгсөн эсэх нь актаар баталгаажихгүй байна. Мөн Эвлэл ХХК-ны худаг гаргах ажлыг гүйцэд хийгээгүй хүлээлгэж өгөөгүй байхад авлагаас үндэслэлгүй бууруулсан байна. Жаргалант сумын ОНХС-гийн хөрөнгөөс ажил гүйцэтгэхээр авсан зарим ажлууд одоог хүртэл хүлээлгэж өгөөгүй төсвийн хөрөнгийг дансандаа байршуулан ашиглаж байгаа зөрчлүүд байна. Тухайлбал:

- ✓ *ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлыг бүрэн хийгээгүй, хүлээн авсан актаар баталгаажаагүйтэй холбоотой он дамжсан авлагыг 2017 онд хөрөнгийн бүртгэлд бүртгэж данснаас хассан 330.2 сая төгрөг байгаа нь ажлаа бүрэн гүйцэд хийж хүлээлгэж өгсөн эсэх нь хүлээн авсан актаар баталгаажиж нотлогдохгүй, авлага үндэслэлгүй бууруулсан гэх үндэслэл байгааг дахин хянаж үр өгөөжийг дээшлүүлэх, актаар баталгаажуулах зөвлөмж өгөх*

³¹ төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх

³² ОНХС-ийн санхүүжилтийн нээсэн эрхийг үндэслэн тухайн орон нутагт төсвийн санхүүжилт хийдэг албан тушаалтнууд зохих журмын дагуу хянаж гүйлгээг хийнэ

³³ төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

- ✓ ОНХС-гаар Мандах наран хороололд цахилгаан дамжуулах агаарын шугам татах ажлыг Ирмүүн аргамаг ХХК-нь ТШ-2016-01/07 гэрээгээр гүйцэтгэхээр гэрээ хийсэн боловч эзэнгүй газар гэсэн шалтгаанаар хугацаандаа хүлээлгэж өгөөгүй төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулж байгаад 21.9 сая төгрөгийн алданги тооцож төсөвт буцаан төвлөрүүлэх 136.5 сая төгрөгийн акт бичих. Энэ нь ОНХС-гийн заавар журмын 11-р зүйлийн 11.2.2³⁴-дахь заалт, Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8³⁵-дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй
- ✓ Он дамжин тооцоо нийлж баталгаажуулаагүй авлага болох Маралгуа ХХК-ны 4.9 сая төгрөг, Атилла констракшнь ХХК-ны 44.8 сая төгрөг нийт 49.7 сая төгрөгийн актын төлбөрийг барагдуулах хуулийн байгууллагад шилжүүлэх

Бүлэг 1.3: ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд ИТХ болон Дотоод аудит хяналтын алба нь хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

ОНХС-аас санхүүжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий нэгжүүд болох ИТХ-ын хяналтын хороо, дотоод аудитын алба, хөрөнгө оруулалт хөгжлийн хэлтсүүд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

1.3.1 Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсээс ямар нэгэн хяналтыг хийсэн талаар аудитын хугацаанд ямар нэгэн мэдээллийг гаргаж өгөөгүй, аймгийн ОНХС-гийн хувиарлалтыг хийхдээ хэдэн иргэдээс санал авч хэрхэн эрэмбэлсэн нь тодорхой бус байна. Мөн Сангийн яамны сайтад тавьсан мэдээллээс иргэдийн санал авсан нь тодорхой харагдахгүй, ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын зургийг байршуулаагүй байгаа нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тогтоолын 9.5³⁶-дахь заалт хэрэгжихгүй байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалын 9.1³⁷-дэхь заалт болох ОНХС-гийн санхүүжилтээр хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд орон нутгийн дотоод аудитын болон иргэдийн хөндлөнгийн хяналт тавина гэж заасан байхад Дотоод аудит хяналтын алба нь Цэцэг сумын ОНХС-гийн санхүүжилтээр хийгдсэн төсөл арга хэмжээнд хяналт тавьснаас өөр сумуудад хяналт тавиагүй байгаа нь ОНХС-гийн 43 дугаар тушаалын 9.6³⁸-д заасан заалтийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар сумын ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас, бүтэн жилийн тайланг аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэст ирүүлэхээр зааж өгсөн боловч тайлангаа ирүүлсэн сум байхгүй

³⁴ ОНХС-ийн санхүүжилтийн нээсэн эрхийг үндэслэн тухайн орон нутагт төсвийн санхүүжилт хийдэг албан тушаалтнууд зохих журмын дагуу хянаж гүйлгээг хийнэ

³⁵ төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

³⁶ Аймаг нийслэлийн ЗДТГ нь аймаг нийслэлийн түвшинд ОНХС-ийн хэрэгжилтийг санхүүгийн болон бусад хяналт шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтээр мэдээллийн сан байгуулах, мэдээллийн санг холбогдох мэдээллээр тогтмол баяжуулж байх.

³⁷ ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана

³⁸ ОНХС-гийн санхүүжилтээр хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд орон нутгийн дотоод аудитын болон иргэдийн хөндлөнгийн хяналт тавина. Орон нутгийн иргэдийн хөндлөнгийн хяналтын тайланг дотоод аудитын тайлангийн хамт Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэр, залруулга, арга хэмжээг авна

байгаа нь 43-р дугаар тушаалын 10.2³⁹-дахь заалт, 10.3⁴⁰ дахь заалтийг хэрэгжилт хангагдахгүй байна. /Хүснэгт-5/

Иргэдээс авсан санал асуулгаар “Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд бодитой хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавьдаг уу” гэсэн асуултад оролцсон иргэдийн 52.1 хувь буюу 186 иргэн үгүй, “Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн		Дүн	Эзлэх хувь
Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд бодитой хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавьдаг уу	Тийм	171	47.9
Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудад хэр сэтгэл хангалуун байдаг бэ	Үгүй	186	52.1
	Хангаттай	159	44.5
	Хангалтгүй	96	26.9
	Мэдэхгүй	102	28.6

байгуулалтын ажлуудад хэр сэтгэл хангалуун байдаг вэ” гэсэн асуултад 26.9 хувь буюу 96 иргэн хангалтгүй, 28.6 хувь буюу 102 иргэн мэдэхгүй байна гэж хариулсан байна. Энэ судалгаанаас үзэхэд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажилд иргэдийн зүгээс тавих хяналт хангалтгүй байна.

ОНХС-гийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг аймгийн Засаг дарга захирамж гарган байгуулаагүй байгаа нь ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилт хангалттай хэрэгжсэн эсэх нь тодорхой бус байна.

Шилэн дансны тухай хуулийг зарим сумууд мөрдөн ажиллаагүй байна.

1.3.2 Сум болон аймгийн ОНХС-ийн шилэн дансны тухай хуулийн 6.3.9⁴¹-д заасан мэдээллийг шилэн дансны сайтад бүрэн оруулсан эсэхийг хянахад дараах байдалтай байна.

- ✓ Буянт, Зэрэг, Манхан, Ховд, Чандмань, Жаргалант сумууд нь хуульд заасан мэдээллийг цаг тухай бүр үнэн зөв бүрэн оруулж хэвшсэн байна.
- ✓ Алтай сум нь хөтөлбөрийн тоо хэмжээ дутуу, гэрээний дүн, олгосон санхүүжилтийг мэдээлээгүй байна.
- ✓ Үенч, Мөст, Дарви, Дуут, Цэцэг, Мөнххайрхан, Мянгад, Дөргөн, Булган сумууд нь шилэн дансны сайтад ямар ч мэдээлэл байршуулаагүй байна.

³⁹ Ажлын хэсэг ОНХС-гийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг сум, дүүрэг бүрээр гарган аймаг нийслэлийн Засаг даргад танилцуулж, шаардлагатай бол ИТХ-аар жил брийн 2 дугаар сарын 25-ны дотор хэлэлцүүлнэ

⁴⁰ Аймаг нийслэл ОНХС-гийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн тайлан, гарсан санал зөвлөмжийн хамт жил бүрийн 3 дугаар сарын 10-ны лотор Сангийн яамны ОНХС-гийн нэгдсэн хэлтэст ирүүлнэ

⁴¹ Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно

БҮЛЭГ 2: Сумдын сум хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүй, зээл, зээлийн хүүгээс орох орлогын эх үүсвэрийн бүрэн төвлөрүүлээгүйгээс сангийн зээлийн эргэц удаашралтай байна.

Сумдын сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт хангалтгүй байна.

2.1.1 Сум хөгжүүлэх санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг тухайн суманд ЖДҮ-лэл, хөгжсөн байдал хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, зээлийн эргэн төлөлт ашиглалт, хэрэгцээ шаардлага орон нутгийн идэвх санаачилга зэргийг харгалзан эх үүсвэрийг бүрдүүлсэн байна. .

2.1.2 Улсын төсвөөс сум хөгжүүлэх санд 2010 онд 13.8, 2011 онд 1225.0, 2013 онд 2450.0, 2014 онд 635.3 , бүгд 4324.1 сая төгрөгийн санхүүжилт олгогджээ. Аймгийн хэмжээнд 2011-2017 онуудад 8350.6 сая төгрөгийн зээл олгож сангийн дансанд 4301.8 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрүүлж, зээлийн эргэн төлөлтийн хувь дунджаар 57.9 хувьтай байна.

Хүснэгт -6 Эх үүсвэрийн эргэц, эргэн төлөлтийн хувь, сангийн хөрөнгийн эргэц

д/д	Сумдын нэр	улсын төсвөөс олгосон эх үүсвэр	олгосон зээл	эх үүсвэрийн эргэц	төлөх үндсэн зээл, хүү	төлсөн үндсэн зээл, хүү	эргэн төлөлтийн хувь	сангийн хөрөнгийн эргэц
1	Алтай	204.0	412.7	2.0	383.4	220.7	57.56	0.53
2	Булган	350.0	630.2	1.8	586.9	291.6	49.68	0.46
3	Буюнт	221.1	547.6	2.5	492.7	384.7	78.08	0.70
4	Дарви	186.5	356.9	1.9	261.5	175.4	67.07	0.49
5	Дуут	187.5	282.5	1.5	291.6	104.3	35.77	0.37
6	Дөргөн	204.0	408.3	2.0	291.5	104.3	35.78	0.26
7	Зэрэг	215.6	401.3	1.9	330.9	215.3	65.06	0.54
8	Манхан	200.0	509.0	2.5	414.9	360.9	86.98	0.71
9	Мөст	210.1	367.4	1.7	338.9	161	47.51	0.44
10	Мөнххайрхан	183.7	390.6	2.1	301.3	229.6	76.20	0.59
11	Мянгад	208.0	327.3	1.6	288.4	134.2	46.53	0.41
12	Жаргалант	980.4	2,266.8	2.3	2,097.7	1339.6	63.86	0.59
13	Ховд	209.5	254.6	1.2	237.5	69.3	29.18	0.27
14	Үенч	204.0	284.0	1.4	306.8	99.2	32.33	0.35
15	Чандмань	207.4	342.8	1.7	289.6	137.9	47.62	0.40
16	Цэцэг	186.5	304.1	1.6	240	150.6	62.75	0.50
17	Эрдэнэбүрэн	165.8	271.7	1.6	273.4	123.2	45.06	0.45
	НИЙТ ДҮН	4,324.1	8,357.8	1.8	7,427.0	4,301.8	57.9	51.5

- Аймагт сум хөгжүүлэх сан хэрэгжиж эхэлснээс хойш 7 жил өнгөрч, зээлийн эргэц 3 жилээр байхад аймгийн хэмжээнд олгосон зээлийн эх үүсвэрийн өсөлтийн 1.8 дахин байна. Зээлийн эргэцийг сум бүрээр тооцвол Буянт 2.5, Манхан 2.5, Жаргалант 2.3, Мөнххайрхан 2.1, Алтай, Дөргөн сумууд 2 эргэсэн байхад Булган, Дарви, Дуут, Зэрэг, Мөст, Мянгад, Ховд, Үенч, Цэцэг, Чандмань, Эрдэнэбүрэн сумууд 1.2-1.9 байна.
- Сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээл олгож эхэлснээс хойш зээлийн гэрээний дагуу 7427.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс үндсэн зээл, зээлийн хүүгийн орлогоос 4301.8 сая төгрөгийг сангийн дансанд төвлөрүүлж зээлийн эргэн төлөлт аймгийн дүнгээр 57.9 хувьтай байна. Зээлийн эргэн төлөлтийн хувийг сумдаар авч үзвэл: Манхан 86.9, Буянт 78, Мөнххайрхан 76.2, Зэрэг 65, Дарви 67, Жаргалант 63, Цэцэг 62, Алтай 57.5 хувь байхад Булган 49.7, Чандмань 47.6, Мөст 47, Мянгад 46.5, Эрдэнэбүрэн 45, Дуут 35.7, Дөргөн 35, Үенч 32.3, Ховд сум 29.1 хувь байгаа нь зээлийн эргэн төлөлт, гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.

Сангийн хөрөнгийн эргэц аймгийн хэмжээнд 51.5 хувьтай байна. Сум бүрээр тооцоход:

- Манхан 71.0, Буянт 70, Жаргалант, Мөнххайрхан 59, Зэрэг 54, Алтай 53, хувь буюу аймгийн дунджаас дээгүүр Цэцэг 50, Дарви 49, Булган 46, Эрдэнэбүрэн 45, Мөст 44, Мянгад 41, Чандмань 40, Дуут 37, Үенч 35, Ховд 27, Дөргөн 26 хувь буюу хөрөнгийн эргэц нь нийт сангийн хөрөнгийн эргэцийн дунджаас доогуур байна.

Сангийн хөрөнгийн төлөвлөлтийг авлага, зээлийн эргэн төлөлттэй уялдуулж төлөвлөөгүй байна.

2.1.3.Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу аймгийн ТЕЗ-ын 2017 онд СХС-ийн орлогыг 1678.6 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр баталсан байна.

СХС-ийн хугацаа хэтэрсэн авлага 2016 оны жилийн эцсийн байдлаар 3128.0 сая төгрөг, 2017 онд гэрээгээр төлөх зээл, зээлийн хүүгийн орлого 1097.1 сая төгрөг нийт 4225.1 сая төгрөгийг сангийн дансанд төвлөрүүлэхээр төсөвлөх байтал тухайн оны сангийн орлогыг 1678.6 сая төгрөгөөр баталсан нь төлөвлөлтийг авлага, зээлийн эргэн төлөлттэй уялдуулж төлөвлөөгүй байна.

Хүснэгт 7. Сангийн төлөвлөлтийн судалгаа

д/д	Сумдын нэр	хугацаа хэтэрсэн авлага	2017 онд гэрээгээр төлөх	нийт	2017 оны төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Алтай	133.8	52.9	186.7	136.6	50.1
2	Булган	326.8	58.4	385.2	105.1	280.1
3	Буянт	94.3	101.5	195.8	65.0	130.8
4	Дарви	126.1	30.8	156.9	46.3	110.6
5	Дуут	183.7	15.4	199.1	11.3	187.8
6	Дөргөн	167.2	32	199.2	50.0	149.2
7	Зэрэг	146.1	35.9	182	167.8	14.2
8	Манхан	58.3	70.1	128.4	180.8	(52.4)
9	Мөст	99.3	101.5	200.8	25.8	175.0
10	Мөнххайрхан	80.7	43.9	124.6	62.6	62.0
11	Мянгад	144.1	34.1	178.2	160.9	17.3

12	Жаргалант	883.4	361.2	1244.6	250.0	994.6
13	Ховд	162.7	22	184.7	51.6	133.1
14	Үенч	135.6	34.9	170.5	132.1	38.4
15	Чандмань	158.7	40.6	199.3	73.3	126.0
16	Цэцэг	92.7	32.1	124.8	119.7	5.1
17	Эрдэнэбүрэн	134.5	29.8	164.3	39.7	124.6
	НИЙТ ДҮН	3,128	1097.1	4225.1	1,678.6	2,546.5

“Ахуй үйлчилгээ”-г хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд олгосон тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй байна.

2.1.4. Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/221 тоот тушаалаар “Ахуй үйлчилгээ”-г хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, гар утас засвар, хувцас, гутал засвар захиалга, үсчин, гоо сайхны чиглэлээр тоног төхөөрөмж худалдан авч аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн даргын тушаалаар сумдад хуваарилсан байна.

- зарим сумдад ахуй үйлчилгээний чиглэлээр олгосон тоног төхөөрөмжийг ашиглаагүй ЗДТГ-ын агуулахад хадгалагдаж байна. Тухайлбал: Мөнххайрхан, Эрдэнэбүрэн, Чандмань, Мөст, Дарви, Ховд, Мянгад сумдад 19.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж хадгалагдаж,
- Буянт 5.3, Чандмань 5.0, Зэрэг 7.9, Мөнххайрхан 2.7 сая буюу 20.7 сая төгрөгийн зарим нэг тоног төхөөрөмжийг сумын Засаг даргын албан тоотоор Хөдөлмөрийн хэлтэст буцаан шилжүүлсэн байна. Уг шилжүүлсэн хөрөнгийн эзэмшил, ашиглалт хамгаалалттай холбоотой мэдээллийг ХХҮГ-аас авахаар албан тоот явуулсан боловч хариу ирүүлсэнгүй.

Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хугацаа хэтэрсэн үлдэгдэлд алданги тооцоогүй байгаа нь журмын 2.1.4-д заасан заалт хэрэгжихгүй байна.

2.1.5 Сум хөгжүүлэх сангийн журмын 2.1.3⁴²-д зааснаар 2017 онд зээлийн гэрээгээр

44.0 сая төгрөгийн хүүгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн боловч 43.7 сая төгрөгийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлж хүүгийн орлогыг 0.3 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн байна.

2.1.6 Журмын 2.1.4⁴³-д зааснаар хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүнд алданги ногдуулна. Алдангийн хувь хэмжээг зээлийн гэрээнд тодорхой хувиар авахаар журмын 1.7⁴⁴-д заасны дагуу тооцож авахаар тусгасан ч алданги тооцож аваагүй дутагдал ихэнх сумдад байна.

- Жаргалант сум 4.0, Зэрэг 0.7, Манхан 0.1, Мөнххайрхан 0.7 бүгд 5.5 сая төгрөгийн алданги 2017 онд тооцож сангийн дансанд төвлөрүүлсэн,
- Алтай, Булган, Үенч, Буянт, Дарви, Дэргэн, Дуут, Мянгад, Мөст, Ховд, Цэцэг, Чандмань, Эрдэнэбүрэн сумууд алданги тооцоогүй байна.

⁴² Сангаас олгосон зээлийн хүүгийн орлого

⁴³ Хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги

⁴⁴ Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчтэй байгуулах Зээлийн гэрээнд тодорхой тусгана.

2.1.7. Сумдын сум хөгжүүлэх сангийн дансанд аймаг сумын төсвийн хөрөнгө болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс хандивын орлого ороогүй байна.

Сум хөгжүүлэх сангийн дансаар бусад орлого төвлөрүүлэн зарцуулж байгаа нь журмын 1.4-д заасан заалттай нийцэхгүй байна.

2.1.8. 2017 онд сангийн дансанд нийт 1052.5 сая төгрөгийн орлого бүрдсэнээс зээл, зээлийн хүү, алдангийн орлого 903.9 сая, малжуулах төсөл, өвсний үнэ, тракторын үнэнд 148.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн нь журмын 1.4-д⁴⁵ заалтыг зөрчиж байна.

БҮЛЭГ 2.2 Журамд заасан шалгуурыг хангаагүй зээлдэгчдэд зээл олгосон, зээлийг зориулалт бусаар зарцуулсан, зээлийн гэрээнд заасан хугацаанд зээлээ төлдөггүй зэргээс шалтгаалж сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулжээ.

Чанаргүй, эдийн засгийн тооцоо, судалгаа муутай төсөлд барьцаа хөрөнгөгүйгээр зээл олгож, зээлийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж байгаа нь журмын холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

2.2.1 Аймгийн хэмжээнд 2011-2017 он хүртэл 1547 төсөлд 8350.6 сая төгрөг олгожээ. Үүнээс 2017 онд 196 төсөлд 790.2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг аж ахуйн нэгж, иргэнд жилд 3 хувиар тооцон 36 сар хүртэлх хугацаатай олгосон байна.

Хүснэгт 8: 2017 оны СХС дансны эхний үлдэгдэл, зээл олголт, эцсийн үлдэгдлийн судалгаа

№	Сумын нэр	эхний үлдэгдэл	орлого	зарлага	эцсийн үлдэгдэл	2017 оны зээл олголт	
						Зээлдэгчийн тоо	Зээлийн хэмжээ
1	Алтай	4,2	25,0	21,1	8,1	4	18,0
2	Булган	0,1	95,5	57,6	38,0	19	45,0
3	Буянт	5,0	87,9	35,9	57,0	3	33,0
4	Дарви	11,3	58,3	55,7	13,9	26	55,7
5	Дуут	1,3	11,9	1,3	11,9	1	1,3
6	Дөргөн	21,2	21,3	42,4	0,1	11	42,3
7	Зэрэг	17,8	68,3	59,3	26,8	8	58,0
8	Манхан	111,0	76,2	140,0	47,1	14	137,5
9	Мөст	0,8	23,8	23,9	0,7	9	22,8
10	Мөнххайрхан	5,2	54,2	38,7	20,7	13	37,0
11	Мянгад	10,9	31,8	23,9	18,9	6	19,5
12	Жаргалант	24,7	238,9	233,7	29,9	48	217,5
13	Ховд	1,6	16,4	0,6	17,4	-	-
14	Үенч	13,4	20,4	3,5	30,3	-	-
15	Чандмань	14,6	158,6	161,9	11,4	25	55,9
16	Цэцэг	19,7	42,6	40,0	22,2	6	40,0
17	Эрдэнэбүрэн	14,7	21,5	7,1	29,1	3	6,7
	Нийт дүн	277,6	1 052,5	946,5	383,6	196	790,2

⁴⁵ Сум хөгжүүлэх сангийн Төрийн сангийн дансанд сангийн хөрөнгөөс бусад хөрөнгө байршуулахыг хориглоно

Сумууд зээлийн хүүгийн 50 хувийг зарцуулах саналыг ИТХ-д өгч төсвийг батлуулаагүй байна.

2.2.2 ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолын 1.8⁴⁶-д тухайн жилийн хүүгийн орлогын тодорхой хувийг сангийн үйл ажиллагаанд зарцуулахыг тусгажээ.

Хүснэгт -9 /хүүгийн орлогын зарцуулалт/

д/д	Сумдын нэр	хүүгийн орлого	нийт зарцуулах эрх	үүнээс		зарцуулалт	
				мэргэжил арга, сургалтад	хяналтын зарцуулах эрх	мэргэжил арга, сургалтад	хяналтын зарцуулах эрх
1	Алтай	1.4	0.7	0.4	0.3	-	0.3
2	Булган	0.2	0.1	0.1	0.0	-	0.7
3	Буянт	4.5	2.3	1.4	0.9	-	0.6
4	Дарви	4.1	2.1	1.2	0.8	-	-
5	Дуут	0.2	0.1	0.1	0.0	-	-
6	Дөргөн	0.5	0.2	0.1	0.1	-	-
7	Зэрэг	3.7	1.9	1.1	0.7	-	-
8	Манхан	2.9	1.5	0.9	0.6	-	0.03
9	Мөст	1.6	0.8	0.5	0.3	-	0.15
10	Мөнххайрхан	1.9	1.0	0.6	0.4	-	-
11	Мянгад	1.3	0.7	0.4	0.3	-	-
12	Жаргалант	12.3	6.2	3.7	2.5	-	-
13	Ховд	0.4	0.2	0.1	0.1	-	0.47
14	Үенч	0.5	0.3	0.2	0.1	-	-
15	Чандмань	4.4	2.2	1.3	0.9	-	0.3
16	Цэцэг	2.7	1.4	0.8	0.5	-	-
17	Эрдэнэбүрэн	1.1	0.6	0.3	0.2	-	-
НИЙТ ДҮН		43.7	21.8	13.1	8.7	-	2.6

Сум хөгжүүлэх сангийн дансанд 2017 онд төвлөрүүлсэн 43.7 сая төгрөгийн хүүгийн орлогоос 30 хувь буюу 13.1 сая төгрөгийг сургалт, мэргэжил арга зүйн дэмжлэгийн зардалд, 20 хувь буюу 8.7 сая төгрөгийг төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зарцуулах эрх зүйн орчин үүссэн байна. Зээлийн хүүгийн тодорхой хувийг зарцуулах саналыг ИТХ-аар төсвийг батлуулаагүй, нэг ч төгрөгийн зардал гараагүйгээс харахад сангийн зээлийн талаар иргэдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах ажил туйлын хангалтгүй журмын 1.8-д дахь заалт хэрэгжээгүй байна.

- Алтай, Булган, Мөст, Манхан, Ховд сумууд 2.6 сая төгрөгийг хяналтын үйл ажиллагаанд зарцуулж бусад сумууд зардал гаргаагүй байгаа нь хяналтын чиг үүрэг хэрэгжээгүй байна.

⁴⁶ сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна”

Сум хөгжүүлэх сангаас олгож байгаа хөнгөлөлттэй зээлийг үндэслэл тооцоо муутай төсөлд олгосон, зээлийн хувийн хэргийн бүрдэлт шаардлага хангахгүй байгаа нь журмын холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.2.3 Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг сонгон шалгаруулахдаа орон нутгийн онцлогт түшиглэсэн үйлдвэрлэл, суманд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглээгүй оновчтой бус, ямар чиглэлд эрэлт хэрэгцээ их байгаа, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох талаар гаргасан нэгдсэн судалгаагүй, төсөл хэрэгжих баталгаа, үндэслэл тооцоо муутай, нэг төрлийн төсөлд хавтгайруулан болон хэт жижиглэн олгодог зөрчил дутагдал байна. Тухайлбал:

- *Жаргалант суманд газар тариалан эрхлэх чиглэлээр 1.0 сая төгрөгийг 23 иргэнд олгосон,*
- *Булган сум 2017 оныг “газар тариаланг” дэмжих жилийн хүрээнд олон төслийг хамруулах зорилгоор нэг чиглэлийн төсөлд 1.0-16.0 сая төгрөгөөр хэт хавтгайруулан олгосон,*

2.2.4 Журмын 4.5⁴⁷-д төслийн сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор Засаг дарга зээл олгох шийдвэр гаргана гэсэн заалтыг зөрчиж байна. Тухайлбал: Жаргалант сумын орон тооны бус зөвлөлийн ирц бүрдээгүй байхад хуралдаж хуралдааны шийдвэр бүрэн бус байхад сумын Засаг дарга нь шууд захирамж гарган зээлийг олгож байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсэж байна.

2.2.5 Журмын 4.6-д “сумын Засаг дарга төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдтэй зээлийн болон барьцааны гэрээг байгуулснаас хойш ажлын 7 хоногийн дотор зээлийн хөрөнгийг зээлдэгчийн дансанд шилжүүлнэ” гэсэн заалтыг зөрчин зарим тохиолдолд он дамжуулан олгодог зөрчил дутагдал түгээмэл байна. Тухайлбал:

- *Жаргалант сум 8 иргэнтэй холбоотой 40.8 сая төгрөг*
- *Зэрэг сумын Засаг даргын 2017 оны 5 дугаар сард 34 тоотор 8 иргэнд 58.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгохоор захирамж гарч 7 дугаар сарын 5-нд 50.0, 9 дүгээр сарын 5-нд 8.0 сая төгрөг,*
- *Алтай сум ЗД-ын А/89 тоотор 5 иргэнд 40.0 сая төгрөгийн зээл олгох захирамж гарсан боловч 10 дугаар сард 18.0 сая төгрөгийн зээл олгож, захирамжаас 22.0 сая төгрөгөөр дутуу олгосон нь журмын холбогдох заалтыг мөрдөөгүй,*

2.2.6 СХС хариуцсан мэргэжилтэн зээлдэгчийн анкет, зээл хүссэн өргөдөл, оршин суугаа хаягийн тодорхойлолт төслийн баримт бичиг, зээл болон барьцааны гэрээ, зээлийн эргэн төлөлтийн хуваарь, барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээг эх хувиар хавсаргахаар заасан боловч хувийн хэргийн бүрдэлт шаардлага хангагдаагүй байхад төслийн зээлийг олгодог зөрчил дутагдалд өмнөх аудитаар зөвлөмж өгөгдсөөр байтал дахин давтан гарсаар байна.

⁴⁷ Энэ журмын 3.3.3-т заасан зөвлөлийн шийдвэр гаргаснаас хойш 14 хоногийн дотор тухайн сумын Засаг дарга зээл олгох шийдвэр гаргана.

- *Жаргалант, Мөнххайрхан, Мянгад, Чандмань, Булган, Алтай, Үенч, Зэрэг, Манхан, Чандмань, Буянт, Дарви, Дуут, Дөргөн, Мөст, Ховд, Цэцэг, Эрдэнэбүрэн зэрэг бүх сумдад хувийн хэргийн иж бүрдэл дутуу байхад зээл олгосон,*

2.2.7 Аж үйлдвэрийн сайдын 2016 оны СХС-ийн гэрээний загвар тайлан авах маягт батлах тухай 72 тоот тушаалаар баталсан “Сум хөгжүүлэх сангаас олгох зээл, барьцааны гэрээний загвар”-ын 9-д “гэрээ дуусгавар болох буюу түүнийг цуцлах” тухай 9.1-9.5 дахь заалтыг зээлийн гэрээнд тусгаагүй гэрээг байгуулсан дутагдал бүх сумдууд түгээмэл байна.

Журмын хэрэгжилт хангаагүй зээлдэгчид зээл олгосноос зээлээ хугацаандаа төлдөггүй эрсдэл түгээмэл байна. /График-5/

2.2.8 Журамд зааснаар зээлдэгч нь ЖДҮ-лэл эрхлэх зохих мэдлэг туршлагатай байх түүнийг нотлох бичиг баримт хавсаргах, төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг бодитой тодорхойлсон, даван туулах арга замыг тусгасан байх, зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж зээлийг хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай барьцаа хөрөнгөтэй байх гэсэн шалгуурыг хангаагүй зээлдэгчдэд зээл олгосон нь зээлээ хугацаандаа төлдөггүй эрсдэл үүссэн байна.



- *Аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар хугацаа хэтэрсэн 3291.7 сая төгрөгийн үндсэн зээл зээлийн хүүгийн үлдэгдэлтэй байгаагаас 624.8 сая төгрөгийн зээл авсан зээлдэгч нарыг аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжсэн, хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүг сангийн дансанд төвлөрүүлэх зөвлөмж өгөх,*
- *2017 онд зориулалт бусаар 40 зээлдэгчтэй холбоотой 266.7 сая төгрөгийн зээл олгосон зөрчил дутагдал илэрсэн тул төлбөрийн акт бичлээ.*

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газраас СХС-ийн зээлтэй холбоотой 624.8 сая төгрөгийн зээлээс 421.6 сая төгрөгийн зээл барагдуулсан гэсэн шийдвэр гүйцэтгэлийн судалгааг албан тоотоор ирүүлснийг аудитын явцад нотлогдохгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн төслийн үр дүнд ажлын байр бодитой нэмэгдсэн эсэхийг баталгаажуулах боломжгүй байна.

2.2.9. “Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн санал, хүлээн авах сонгон шалгаруулах журам”-ын 4.3.6-д “ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байх” гэж заасны дагуу шалгалтын явцад сангийн хөрөнгийн үр дүнд ажлын байр нэмэгдсэн нь тодорхой бус, аудитаар нотлох боломжгүй байна. Аймгийн ХХААГ болон ЗДТГ-

ын жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтнүүдэд зээл авснаар нэмэгдсэн ажлын байрны нэгдсэн тоо судалгаа мэдээлэл байхгүй байна.

Сумдын ИТХ нь журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

2.2.10. Журмын 3.4⁴⁸, 3.3.2⁴⁹, 3.3.3⁵⁰ -д сумын ИТХ-ын хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу сумууд ИТХ-аар аж ахуйн нэгж, иргэнд олгох зээлийн дээд хэмжээ, төсөл сонгон шалгаруулах болон зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг томилон ажиллуулахаар заажээ. Гэвч сумууд орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2016 оны 153 дугаар тогтоолын дагуу байгуулаагүй байна. Тухайлбал: Багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэн сонгосон байх, баг тус бүрээс нэг иргэний төлөөлөл, баялаг бүтээгчдийн холбоо болон банкны төлөөлөл оролцуулан байгуулна гэснийг ихэнх сумууд мөрдөж ажиллаагүй байна.

- *Жаргалант сумын 2017 онд ИТХ-ын 39 дүгээр тогтоолоор зээлийн дээд хэмжээ, төсөл сонгон шалгаруулах болон хяналт тавих орон тооны бус зөвлөлийг томилсон боловч СХС төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн журмын заалтыг хангаагүй,*
- *Ховд сум 2011 оны ИТХ-ын 37 дугаар тогтоолоор зээлийн дээд хэмжээ, төсөл сонгон шалгаруулах болон хяналт тавих орон тооны бус зөвлөлийг томилсон 2012 онд сумын Засаг дарга ИТХ-ын Тэргүүлэгч нар нь өөрчлөгдсөн ч дээрх тогтоолыг шинэчлээгүй, 2018 оны 5 дугаар сард сумын ИТХ-ын 23 тоот тогтоолоор шинэчилсэн,*
- *Буюнт сумын төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн гишүүнд 2017 онд “Шинэ санаа Буюнт” сүлжмэл эдлэл хийх чиглэлээр 15.0 сая төгрөгийн зээл авсан боловч тухайн зөвлөлийн хуралд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ мэдүүлээгүй, орон тооны бус зөвлөлийн даргаар сумын Засаг даргын орлогчийг томилсон,*
- *Зэрэг сум төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн даргаар сумын Засаг даргын орлогчийг томилсон,*
- *Манхан сумын орон тооны бус хяналт тавих зөвлөлийн баялаг бүтээгчдийн холбооны гишүүнд 20.0 сая төгрөгийн зээл олгосон,*
- *Дуут сум 2013 оны ИТХ-ын 29 тоот тогтоолоор орон тооны бус төсөл сонгон шалгаруулах болон хяналт тавих зөвлөлийг томилсон боловч Засаг дарга өөрчлөгдсөн тогтоолыг шинэчлээгүй, Төрийн сангийн мэргэжилтэн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүнээр томилсон, хяналт тавих орон тооны бус зөвлөлийн гишүүдэд сумын ИТХ-ын дарга болон төлөөлөгчдийг томилсон,*
- *Мянгад сумын зээлийн ашиглалт эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг 2016 оны сумын ИТХ-ын 18 тоот*

⁴⁸ Энэ журмын 3.3.2, 3.3.3-т заасан зөвлөлийн гишүүн ашиг сонирхолын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллах үүрэгтэй бөгөөд дараах шаардлагыг хангасан байна.

⁴⁹ Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг тухайн сумын ИТХ-ын тэргүүлэгчээр ахлуулан, ЗДТГ-ын төрийн сангийн мэргэжилтэн, баялаг бүтээгчдийн холбоо болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллах

⁵⁰ Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг тухайн сумын Засаг даргаар ахлуулан ЗДТГ-ын ЖДҮ-ийн асуудал хариуцсан мэргэжилтэн, баялаг бүтээгчдийг дэмжих холбоо, банк болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллах

тогтоолоор баталсан боловч зөвлөлийн даргаар сумын ИТХ-ын даргыг томилсон, Төрийн сангийн төлөөлөгчийг оруулаагүй,

- Дарви сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 02 тоот тогтоолоор СХС-ийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг томилохдоо зөвлөлийн даргаар Засаг дарга, санхүү албаны дарга нарыг томилсон, төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийг томилоогүй журмын 3.3 дахь заалтыг зөрчсөн байна.

Жаргалант сумын СХС-ийн төсөл сонгон шалгаруулах болон зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлүүд нь журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

2.2.11. Улсын төсвөөс олгосон санхүүжилт өндөр, зээлдэгч олонтой аймгийн төвийн Жаргалант сумын СХС-ийн үйл ажиллагааг газар дээр нь шалгахад дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- 2017 онд шалгаруулсан төслөөс 7 иргэнд 85.0 сая төгрөгийг зориулалт бус зээлд олгосон,
- Нөлөө бүхий албан тушаалтан иргэдийн нэр дээр зээл авч ашигласан эргэн төлөлт хийгдээгүй зөрчил илэрлээ. Тухайлбал: 1.2012 онд иргэн А.Баясолтонд 15.0 сая төгрөгийн зээл олгосон. Уг зээлийг тухайн үеийн засаг даргаар ажиллаж байсан Мягмарцог авсан, зээлийн үлдэгдэл 4.1 сая төгрөгийг зээл авсан хүн төлөх ёстой гэсэн тайлбар бичиж өгсөн.

2. 2014 онд иргэн Г.Саруулд 32.0 сая төгрөгийн зээл олгосон байна. Уг зээлийг тухайн үед ЗДТГ-ын хууль зүйн хэлтсийн дарга Даваахүү хамтран зээлдэгчээр орж зээлийг авч ашигласан. Миний хувьд нэг ч төгрөг аваагүй., Гэрээнд өөрчлөлт оруулж Монгол банкны мэдээллийн санд Даваахүүгийн нэр дээр оруулж зээлийг төлүүлэх арга хэмжээ авч өгөхийг хүсэж бичгээр тайлбар гаргасан,

- Харьяалалын бус УБ хотын иргэн М.Энхсайханд 5.0 сая төгрөгийн зээл олгосон,
- Барьцаа хөрөнгийн байршил харьяаллын бус эзэмшлийн гэрчилгээгээр зээл олгосон.Тухайлбал: Иргэн К.Заяад Зэрэг сумын өмчлөх эрхтэй газрын гэрчилгээгээр 8.0 сая төгрөгийн, иргэн Алтанцэцэг Дарви сумын эзэмших эрхтэй газрын гэрчилгээгээр 10.0 сая төгрөгийн, Иргэн Ч.Даш-Өлзийд Мөнххайрхан сумын өмчлөх эрхийн гэрчилгээгээр 3.0 сая төгрөгийн, О.Бямбасүрэнд УБ хотын Сонгино хайрхан дүүргийн өмчлөх эрхийн гэрчилгээгээр 3.5 сая төгрөгийн зээл олгосон зөвлөмж өгөх,
- Бусдын эзэмшлийн компаний нэр дээр зээл олгосон. Тухайлбал: Вивазоне ХХК-ны нэр дээр иргэн Г.Нямдаваа 22.4 сая төгрөгийн,
- Иргэн К.Нуржуз, хамтран зээлдэгч Баваржан 2014 онд 9.0 сая төгрөгийн зээл авсан эргэн төлөлт хийгдээгүй одоогийн байдлаар

үлдэгдэл 10.1 сая төгрөг байна. Зээлдэгч нь иргэншилээ өөрчилж Казакстан улс руу шилжсэн,

- Зээлдэгчдэд барьцаа хөрөнгөгүй 5 иргэнд 38.5 сая төгрөгийн зээл олгосон, барьцаалсан хөрөнгийн бичиг баримтыг буцаан эздэд нь өгсөн 14 иргэнтэй холбоотой 69.2 сая төгрөгийн зээл олгосон,

Эдгээр зөрчил дутагдал үүсэж байгаа шалтгаан нь СХС-ийн үйл ажиллагаа хэрэгжиж эхэлснээс хойш хариуцсан мэргэжилтэн 8 удаа солигдож төрийн албан хаагчийн тогтвор суурьшилтай ажиллах, ажлын туршлага хуримтлуулах нөхцөл үүсээгүйтэй мөн нөгөө талдаа Жаргалант сумын СХС-ийн төсөл сонгон шалгаруулах, зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих хяналтын орон тооны бус зөвлөлүүдийн бүрэлдэхүүнд томилогдсон гишүүд журмын заалтыг хангаагүй чиг үүргээ биелүүлээгүйтэй холбоотой байна.

2.2.12. Сангийн хөрөнгийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайлан, сар улирлын мэдээг нэгтгэн жилийн тайланд тусгаж байгаа ч сангийн хөрөнгийн тооцоог он бүрээр нь дэлгэрэнгүй хийдэггүй, санхүүгийн тайланд сангийн авлагыг зөрүүтэй тусгаж байна.

- Ховд сумын төрийн сангийн мэргэжилтний 2011-2017 оны зээлийн тооцооны мэдээллийг дэлгэрэнгүй хянахад 2011 онд олгосон иргэний 2.5 сая төгрөгийн зээлийг төлснөөр тооцож оны эцэст авлагаар бүртгээгүй орхигдуулсантай холбоотой сангийн дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт бичих, тайланд авлага нэмэгдүүлэх зөвлөмж өгөх,
- Цэцэг сумын СХС-аас 2015 онд бэлтгэн олгосон 12.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг зээлдэгч нарт хүлээлгэн өгсөн боловч зээлийн гэрээ байгуулаагүй, 2017 оны санхүүгийн тайланд авлагыг 15.9 сая төгрөгөөр дутуу тусгасанд залруулга хийх зөвлөмж өгөх,
- Эрдэнэбүрэн сумын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн зээлдэгч нарын зээл олгосон дэлгэрэнгүй тооцоог хөтөлдөг, төрийн сангийн мэргэжилтэн дансны хуулга боловсруулж байгаа боловч хоорондын ажлын уялдаагүй, тооцоо нийлдээгүйтэй холбоотой тайлан мэдээ, санхүүгийн тайлан дахь авлага зөрүүтэй,

Сум хөгжүүлэх сангийн зээлийн мэдээллийн бүртгэл, хяналт нэгтгэлийн программ шаардлага хангахгүй байна.

2.2.13. СХС-гийн журмын 3.1.4⁵¹-д Монгол банкны мэдээллийн санд зээлдэгчдийн мэдээллийг байршуулахаар заасан ч зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг банкны мэдээллийн санд бүртгэхгүйгээр олгож байна. Өмнөх онд хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар уг заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг ААГ-аас холбогдох албан тушаалтанд үүрэг болгосон. Журмын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 9 дүгээр сарын 25-ны 01/3531 тоот албан бичгээр

⁵¹ Сангаас олгосон зээлийн мэдээллийн санг бүрдүүлэн хөтөлж, холбогдох мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулах

аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газарт “Сум хөгжүүлэх сангийн зээлийн мэдээллийн сангийн бүртгэл, хяналт нэгтгэлийн программ”-д холбогдох мэдээллийг 2018 оны 10 дугаар сард багтаан шивж оруулахаар сургалт зохион байгуулсан байна. Сангаас олгосон зээлдэгчийн мэдээллийг нэгтгэлийн программд бүрэн оруулаагүй цахим санг бүрдүүлэх ажил хэрэгжих шатандаа явагдаж байна.

- *Аудитын явцад СХС-ийн мэргэжилтэнгүйд дээрх программ нь мэдээллийг оруулснаас хойш зээлийн хүүг хуримтлуулж тооцохгүй байгаа болохоор тооцооллыг ексел файл дээр боловсруулж дахин хүн нэг бүрээр шивж оруулж байгаа учир шаардлага хангахгүй байна гэдэг мэдээллийг өгч байна.*
- *Манай аймгийн 17 суманд нэг бүр нь 750.0 мянган төгрөгийн өртөг бүхий программ хангамж худалдан авахад 12750.0 мянган төгрөгийг зарцуулахаар байгаа ч эх үүсвэрийг гаргах зардал журамтай нийцэхгүй, хүлээлгэн өгсөн программ хангамж нь наад захын шаардлага болох хүүг буруу тооцоолж байна. Иймд улсын хэмжээнд гарсан зардлын дүнгээр ХХААЯ-нд албан шаардлага хүргүүлэх саналыг Нийцлийн аудитын газарт уламжилж байна.*

2.2.14. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх сан”, “сум хөгжүүлэх сан”-гийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг байгалийн нөөцийн хэмнэлттэй дэвшилтэт технологид суурилсан, ажлын байр шинээр бий болгох үйлдвэрүүдэд хөрөнгө оруулахад зарцуулахаар аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар 03-ны өдрийн 2/03 тоот тогтоолоор ХАА, МАА, хөнгөн үйлдвэр, худалдаа үйлчилгээний болон барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр батлагджээ.

Иргэдээс авсан судалгаагаар СХС-ийн үйл ажиллагаанд 67.2 хувь нь “хангалтгүй буюу мэдэхгүй” гэсэн үнэлгээ өгсөн нь аймгийн хэмжээнд сангийн хөрөнгийн зарцуулалт хангалтгүй байна.

2.2.15 Аудитын явцад 8 төрлийн асуултаар Жаргалант сум болон бусад сумдын 270 иргэдээс судалгаа авч нэгтгэсэн.

Доорх судалгаанаас үзэхэд СХС-ийн зээлийн талаарх мэдээлэл аймгийн хэмжээнд 55.6 хувь хангалттай, ард иргэдийн 52.6 хувь нь хууль тогтоомж, журам зааврыг судалсан, судалгаанд оролцсон иргэдийн 42.6 хувь нь сангийн үйл ажиллагаанд хангалттай, 34.4 хувь нь хангалтгүй, 23 хувь нь мэдэхгүй гэсэн үнэлгээ өгч байна.

Хүснэгт 10. Нэгтгэсэн судалгаа

		судалгаанд оролцсон иргэний тоо	270	
1 ямар чиглэлийн бизнес эрхэлдэг вэ	үйлдвэрлэл		78	28.9
	үйлчилгээ		101	37.4
	худалдаа		91	33.7
2 СХС-ийн талаар хэр мэдээлэлтэй э	хангалттай сайн		150	55.6
	хангалтгүй		120	44.4
3 СХС-ийн талаарх мэдээллийг яанаас авсан вэ	ЗД хороодын хэсгийн ахлагч		109	40.4
	орон нутгийн мэдээллийн самбар, радио телевиз		49	18.1
	Иргэний танхимын ажилтан		16	5.9
	нутгийн иргэдээс		96	35.6
4 СХС-ийн талаарх холбогдох хууль згтоомж журам зааврыг судалж исэн үү	тийм		142	52.6
	үгүй		128	47.4
5 энэ сангаас зээл авч байсан уу	тийм		148	54.8
	үгүй		122	45.2
ХС нь иргэд ААНЖ-д ЖД, дунд бизнес шинээр эхлэх, бизнесээ слэх, бизнесээ өргөжүүлэх болон ажлын байр нэмэгдэхэд үр нгээ өгч байна уу		2011-2013 онуудад олгосон зээлдэгчид зээлээ төлдөггүй, зарим зээлдэгчид зориулалт бусаар ашигладаг, үр дүн муутай байна, төслөө зөв шалгаруулаагүй, зохих эзэндээ очдоггүй, намын харьяаллаар олгодог, эргэн төлөлтөө хугацаандаа хийдэггүй, танил тал, найз нөхөд, ИТХ-ын төлөөлөгчдийн ах дүүс, албан тушаалтан хүмүүс авдаг		
КС-аас зээл авахад хүндрэл бэрхшээл байна уу		Засаг дарга мэдэж олгодог учраас өөрийн тойрон хүрээний хүмүүст өгдөг, зээлийн эргэн төлөлтөөс санхүүждэг учраас өмнөх зээлдэгч нар зээлээ хугацаандаа төлдөггүйгээс удаан хүлээдэг, бэрхшээлтэй, хүнд суртал их гаргадаг, зээлийн талаар нийтэд мэдээлэл ил тод биш, судалгаа муу учраас төсөл сонгон шалгаруулалтын орон тооны бус зөвлөл нь төслөө зөв сонгож чаддаггүй.		
6 энэ сангийн үйл ажиллагаанд ямар зэлгээ өгөх вэ ?	хангалттай сайн		115	42.6
	хангалтгүй		93	34.4
	мэдэхгүй		62	23

БҮЛЭГ 3. Сангуудын хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, сангийн үйл ажиллагааг нийтэд ил тод мэдээлээгүй, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

ОНХС-ийн өмнөх аудитаар илэрсэн зөрчилд өгсөн актыг барагдуулж ажилласан ч албан шаардлагын 64.1 хувийг арилгаагүй, зөвлөмжийн 20.5 хувийг хэрэгжүүлээгүй байна.

3.1 ОНХС-ийн 2016 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, орон нутгийн удирдлагууд ОНХС-ийн орлогын төлөвлөлт, хуваарилалт, бүрдүүлэлт болон сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулаагүйгээс өмнөх аудитаар илэрсэн зөрчил дутагдал арилахгүй, давтан гарсаар байна. Тухайлбал: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжөөс аймгийн ОНХС, Дуут сумын ОНХС өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, “Иргэдийн саналаар дэмжигдээгүй төсөл, арга хэмжээг ОНХС-ийн төлөвлөгөөнд тусгахгүй байх” гэсэн зөрчил давтагдсан, Үенч, Жаргалант сумын ОНХС нь худалдан авах хууль журам зөрчсөн зөрчлүүд давтан гарсан байна.

/График-6/

Жаргалант сум нь өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлыг хэрэгжүүлэн авлагыг бууруулж хөрөнгийг данс бүртгэлд тусгасан боловч ажлуудыг хүлээн авсан комиссын актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5⁵²-дахь заалт, ОНХС-гийн зааврын 9-р зүйлийн 9.1⁵³-дэхь заалтыг хэрэгжүүлээгүй байна.



2015 оны ОНХС-гийн аудитаар өгөгдсөн зөвлөмжөөс Төмс боловсруулах үйлдвэрийг бүртгэлд тусгах зөвлөмж нь одоог хүртэл хэрэгжээгүй байна. Жаргалант сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийсэн иргэдэд шуудан үйлчилгээний газрыг ойртуулах зорилгоор барьсан барилгыг зориулалт бусаар ашиглаж байгаа, одоо хүртэл хэн эзэмшиж ашиглах талаар тодорхой үр дүнд хүрээгүй, хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан, түрээсийн орлогыг Монгол шуудан ХХК-ны дансанд орж байгаа хөрөнгө эзэмшигч талд ордоггүй, хөрөнгийн маргаантай урьд оны өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал 2015 онд Жаргалант сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн Наран багийн тоглоомын талбайг “Оож өргөө” ХХК нь 10.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн боловч гүйцэтгэл хангалтгүй, авлагаар бүртгэгдсэн дүнг бууруулж шаардлага хангахгүй хөрөнгийг орлогод тусгасан байна. /График-7/



ИТХ-ыг чадавхжуулах төсөл хөтөлбөрийг батлуулахгүй байх зөвлөмж он оны аудитаар өгөгдсөн боловч зогсоогоогүй өмнөх онуудаас өссөн байгаа нь дараах графикаас харагдаж байна. 2018 онд өмнөх оноос 92.0 сая төгрөгөөр буюу 98.6 хувиар өссөн байна. 2016 оны ОНХС-гийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын үр дүнд хийсэн нийцлийн аудитаар



⁵² Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах

⁵³ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт санхүүжилт гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүйгээс 2017 оны аудитаар илэрсэн алдаа зөрчил ихээхэн дүнгээр нэмэгдсэн байна. /График-8/

Графикаас үзэхэд бүртгэл тайланд тусгагдаагүй зөрчил нь өмнөх оноос 3.4 дахин өссөн, дутуу буюу чанаргүй хийгдсэн ажил нь 2016 онд 5.0 сая төгрөг байсан бол 2017 онд 924.3 сая төгрөг болтлоо өссөн байгаа нь аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүйг харуулж байна.

Сум хөгжүүлэх сангийн хэрэгжилтэд аймаг, сумдын ИТХ болон мэргэжлийн байгууллага, холбогдох албан тушаалтнууд журамд заасан эрх үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

- 3.2.1 Жижиг дунд үйлдвэрлэлийн тухай хууль тогтоомж болон ЖДҮ-ийг хөгжүүлэх Засгийн газраас баримталж байгаа бодлогод уялдуулан сумууд ЖДҮ-ийг хөгжүүлэх бодлогын хүрээнд тэргүүлэх чиглэлээ сумынхаа ИТХ-аар батлуулсан боловч энэ нь орон нутгийн давуу тал онцлогт түшиглэсэн үйлдвэрлэл, хөдөө орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглээгүй оновчтой бус, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, ямар чиглэлд эрэлт хэрэгцээ их байгааг гаргасан нэгдсэн судалгаагүй байна.
- 3.1.2. Журмын 3.5.9⁵⁴-д заасны дагуу тухайн үүргийг сумын Засаг дарга нар хэрэгжүүлэхээр заасан боловч аймгийн ЗДТГ-ын ЖДҮ хариуцсан нэгжид мэргэжил арга зүйн дэмжлэг, сургалт зохион байгуулах, оролцоог нэмэгдүүлэх санал сумдаас ирүүлээгүй нь холбогдох заалт хэрэгжээгүй байна.
- 3.1.3 Сангийн хөрөнгийн орлого зарцуулалтын явцад улирал бүр хяналт шалгалт хийж үр дүнг сумын иргэдэд ил тод нээлттэй мэдээлж, ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлдэггүй дутагдал сум бүрт байгаа нь журмын 5.7 дахь заалтын хэрэгжилт хангалтгүй байна.
- 3.1.4. Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгана гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. 2017 онд аймгийн ИТХ-ын захиалга, Төрийн аудитын газрын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу Сум хөгжүүлэх сангийн 2016 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийгдэж нийт 133.1 сая төгрөгний төлбөр зөрчил илэрснээс 8.3 сая төгрөгийн актыг сумдын сангийн дансанд төвлөрүүлэх, 124.8 сая төгрөгийн албан шаардлага бичигдсэн байна. Аудитын дүнд илэрсэн зөрчилд үндэслэн 12 төрлийн зөвлөмж өгч хэрэгжүүлж ажиллахыг Аймгийн ИТХ-ын дарга Г.Пүрэвганди, Засаг дарга Д.Галсандондог, ХХААГ-ын дарга Т.Баатарзориг, СХС хариуцсан мэргэжилтэн Н.Дулам, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга М.Отгонханд, сумдын төрийн сангийн мэргэжилтэн, Сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэнгүүдэд хүргүүлэн ажилласан.

⁵⁴ Сумын иргэн хуулийн этгээдэд ЖДҮ эрхлэн болон бусад шаардлагатай асуудлаар мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх саналаа аймгийн ЗДТГ –ын ЖДҮ хариуцсан нэгжид хүргүүлэх, иргэдийн дунд сургалт зохион байгуулж, оролцоог хангаж ажиллана.

- *Жаргалант сумын хувьд 2017 оны 11 дүгээр сараас 2018 оны хагас жил хүртэл олгосон зээлийн хувийн хэргийн бүрдүүлэлт сайжирсан, зээлдэгч нарын барьцаа хөрөнгийг Улсын бүртгэлийн газарт зээлийн барьцаанд байгаа тэмдэглэгээ болон өндөр дүнтэй зээлдэгчийн зээлийн гэрээний барьцаа хөрөнгөнд хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн, хаврын тариалалтын ажил эхэлсэнтэй холбоотой ногоочдод сургалт зохион байгуулсан, өмнөх онуудад олгосон зээлийн бичиг баримтыг цэгцэлсэн зэрэг үр дүн харагдаж байна.*

/Хүснэгт-11/

д/д	Байгууллага, сумдын нэр	Аудитаар өгөгдсөн			Биелэлт		
		Акт	Албан шаардлага	Зөвлөмж	Акт	Албан шаардлага	Зөвлөмж
1	Жаргалант сум	3.9	124.8		3.9	124.8	
2	Ховд сум	2.2			2.2		
3	Дөргөн сум	1.6			1.6		
4	Дуут сум	0.8			0.8		
5	Холбогдох албан тушаалтан			12			12
	НИЙТ ДҮН	8.5	124.8	12	8.5	124.8	12

Дээрх тодорхой үр дүн харагдаж байгаа хэдийч 2017 оны аудитаар илэрсэн алдаа зөрчлийн тоо өссөн нь зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

3.1.5. Сангийн хөрөнгөөс хөнгөлөлттэй зээл авсан зээлдэгчдээс төслийн үйл ажиллагааны болон зээлийн эргэн төлөлтийн тайланг гаргуулахаар журмын 5.3.1⁵⁵-д заасан боловч аймгийн хэмжээнд зээлдэгч нь зээлийн үйл ажиллагааны тайланг гарган ирүүлээгүй байгаа нь журмын заалтыг мөрдөөгүй байна.

3.1.6. Сумдын Засаг дарга нь

сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг улирал болон жилээр гаргаж журмын 5.4⁵⁶-д заасны дагуу аймгийн Засаг даргад ирүүлээгүй байна.



⁵⁵ Зээл авсан иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн тайланг гаргуулан авах,

⁵⁶ Сумдын Засаг дарга сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг улирал болон жилээр гаргаж, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 20-ны дотор тухайн аймгийн Засаг даргад хүргүүлнэ

3.1.7. Аймгийн Засаг дарга нь журмын 5.5⁵⁷-д зааснаар 2017 оны сангийн орлого зарлагын тайланг нэгтгэн ЖДҮ-ийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн тухай албан тоотой хугацаатай бичиг явуулсан боловч хариу ирүүлсэнгүй.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. **ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар сумууд иргэдийн хэрэгцээнд нийцсэн ажлуудыг хэрэгжүүлж байгаа ч Аймгийн ОНХС, Үенч сум, Дарви сум, Цэцэг сум, Жаргалант сумын ОНХС-гийн гүйцэтгэл хангалтгүй, ОНХС-аас санхүүжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт сул байна.**
2. **Сум хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүй, зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт хангалтгүй, сангийн хөрөнгийн эргэц удаашралтай, журамд заасан шалгуурыг хангаагүй зээлдэгчдэд зээл олгосон, зээлийг зориулалт бусаар зарцуулсан нь сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан, сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, сангийн үйл ажиллагааг нийтэд ил тод мэдээллээгүй, өмнөх гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.**

Аудитаар нийт 6761.1 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 889.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 565.2 сая төгрөгийн албан шаардлага, 5306.5 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж бичигдлээ.

Үүнээс ОНХС-гийн аудитаар нийт 2779.8 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 620.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 565.2 сая төгрөгийн албан шаардлага, 1594.4 сая төгрөгийн зөвлөмж бичигдлээ.

СХС-гийн аудитаар нийт 3981.3 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 269.2 сая төгрөгийн акт, 3712.1 сая төгрөгийн зөвлөмж бичигдлээ.

Аудитын дүнд илэрсэн зөрчилд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аймгийн ИТХ-ын дарга Г.Пүрэвганди, Засаг дарга Б. Дүгэржав нарт

- Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, төсөл сонгон шалгаруулах болон төслийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаагүй, өмнөх гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг биелүүлээгүй Засаг дарга, ИТХ-ын дарга, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох

⁵⁷ Аймгийн Засаг дарга энэ журмын 5.4-т заасан сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн улирлын болон жилийн тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

- СХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулахдаа иргэд, олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах хэрэгжилтийг иргэд, олон нийтийн хяналтад оруулах ажлыг зохион байгуулах;
- ОНХС-гийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Хяналтын хороог байгуулж ажиллуулах
- ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр аймгийн ТЕЗ-аас өргөн мэдүүлж буй төсөл, арга хэмжээний зураг, төсөв, ТЭЗҮ нь хийгдсэн эсэх, холбогдох зөвшөөрлүүд шийдэгдэж, иргэдийн саналаар баталгаажсан эсэхийг хянаж, баталж байх
- ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналтыг ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албаар гүйцэтгүүлж, дүгнэлтийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үр дүнг үнэлэх.
- Аудитаар материаллаг хэмжээний төлбөр зөрчил илэрсэн, өмнөх аудитын зөвлөмжийг биелүүлээгүй, алдааг давтан гаргаж байгаа Дарви, Үенч, Цэцэг, Жаргалант сумдын Засаг дарга, ОНХС хариуцсан мэргэжилтэнгүүдэд хариуцлага тооцож хариуг 2018 оны 12 сарын 20-ны дотор ирүүлэх
- Жаргалант сум, аймгийн ОНХС-гийн 2014-2017 оны ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн авлагаар бүртгэгдсэн хөрөнгө оруулалтыг үндэслэлгүй бууруулсан одоог хүртэл хүлээлгэн өгөөгүй ажлуудад комисс томилон дотоод хяналтыг хэрэгжүүлэн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх

Сумдын Засаг дарга нарт:

- Сумын ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх үүрэг бүхий ажлын хэсгийг томилон ажиллуулах. ОНХС-гийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийн эзэмшигч, ашиглагчийг тухай бүр тогтоож, Орон нутгийн өмчийн газарт жагсаалт хүргүүлэх, хяналт тавих
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг сайжруулах зорилгоор сумдад дотоод хяналтын албыг байгуулж үйл ажиллагааг нь жигдрүүлэн, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд үе шатны хяналтыг тухай бүр хэрэгжүүлж ажиллах талаар тодорхой ажлуудыг хэрэгжүүлж ажиллах

ХХААГ-ын дарга З.Лувсан, ЖДҮ хариуцсан мэргэжилтэн н.Эрдэнэдорж нарт

- СХС-гийн зээлийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг улирал бүр хийж, сангийн мэдээ тайланг үнэн зөв гаргаж аймгийн хэмжээний нэгдсэн мэдээллийн сантай болох ажлыг зохион байгуулах
- Ашиглагдахгүй агуулахад байгаа ахуйн үйлчилгээний зориулалтаар нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн үлдэгдлийн судалгааг гаргаж цаашид ашиглалтыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга М.Отгонханд, ХОХБТХ-ийн дарга Б.Баярсүх, сумдын төрийн сангийн мэргэжилтэн нарт

- Сангийн хөрөнгийн төлөвлөлтийг авлага, зээлийн эргэн төлөлттэй уялдуулж төлөвлөх
- СХСангийн зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ,авлагыг хүн бүрээр тулган үлдэгдлийг баталгаажуулж, авлага бууруулах, авлагыг үнэн бодиттой тайлагнах
- Сумдын төрийн сангийн хяналтыг сайжруулж барьцаа хөрөнгөгүй, хувийн хэргийн иж бүрдэлгүй, зориулалт бус зээл гаргахгүй байх
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тогтоолыг мөрдөн ажиллаж ОНХС-ийн мэдээллийн санг баяжуулах, иргэдээс ирсэн саналуудыг эрэмблэн ИТХ-д оруулж танилцуулж байх, иргэдээс санал гаргаагүй ажлыг ИТХ-аар батлуулахгүй байх.
- ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулсан зарцуулалтад хяналт тавих, үр дүнг тооцох, дахин зориулалт бус үйл ажиллагаанд зарцуулахгүй байх
- Иргэдийн саналыг авах ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, баримтжуулах

Сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэнгүүдэд

- Сангийн хөрөнгийн үйл ажиллагааг иргэдэд ил тод нээлттэй мэдээлэх, төсөл сонгон шалгаруулахдаа сумын иргэдийг оролцоог нэмэгдүүлэх
- Хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааг идэвхжүүлэн чанаргүй зээлийн асуудлыг яаралтай шийдвэрлэж, үр дүнг тооцох
- Ажлын байрыг нэмэгдүүлэх бодитой үр дүн гаргах төслийг сонгон шалгаруулж, зээлийн үр ашгийг дээшлүүлэх
- Сум хөгжүүлэх сангаас олгож байгаа төслийн зээлийн хувийн хэргийн бүрдэлтийн шаардлага хангасан төсөлд зээлийг олгох,
- Сум хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлд алданги тооцох, алдангийг сангийн дансанд төвлөрүүлэх
- Аж үйлдвэрийн сайдын 72 тоот тушаалын Сум хөгжүүлэх сангийн гэрээний загвар, тайлан авах маягт батлах журмыг мөрдөн ажиллах
- Тухайн жилийн зээлийн хүүгийн орлогын зарцуулах саналыг ИТХ-аар батлуулан ажиллах
- Сум хөгжүүлэх сангийн дансанд сангийн хөрөнгөөс бусад хөрөнгө байршуулахгүй байх
- Сангийн үйл ажиллагааны талаар сумын ИХТ хурал журмаар заагдсан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллах

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 03 сарын 25-ны дотор аймгийн Төрийн аудитын газарт ирүүлэх

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 34

Хяад

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 15.2.5 дахь заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1, 1.3 дэх заалт, 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан нийцлийн аудитын түр журмын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт үр дүн"-д хийсэн нийцлийн аудитын тайлан баталгаажуулсугай.

2. Нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталж, акт, албан шаардлагын биелэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг гүйцэтгэсэн аудиторуудад үүрэг болгосугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтэст, Хүнс хөдөө аж ахуйн газар, Жаргалант сумын засаг дарга нарт хүргүүлж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурал, засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг аудитын багт хариуцуулсугай.

4. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 14 хонгийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг аудитор /Д.Мөнхтулга/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер /А.Цэцэгсүрэн/-д тус тус даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР